

**ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ
“МОНГОЛЫН АЛТ” (МАК) ХХК-НИЙ “ХӨӨТИЙН НҮҮРСНИЙ УУРХАЙ”-Н
2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-012199/
/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 2095025/

Хянасан:

БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын ахлах шинжээч

Хэрэгжилтийг гаргасан:

“Монголын Алт” (МАК) ХХК-ний
Үйлдвэр Техникийн Газрын захирал

/Д. Баярсайхан/

Байгаль орчны мэргэжилтэн

/А. Халиунаа/

2022 он



ХӨӨТИЙН НҮҮРСНИЙ ИЛ УУРХАЙ

**ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ
БАЙРЛАХ “ХӨӨТИЙН НҮҮРСНИЙ УУРХАЙ”-Н
2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

**Улаанбаатар
2022 он**



ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ
“МОНГОЛЫН АЛТ” (МАК) ХХК-НИЙ “ХӨӨГИЙН НҮҮРСНИЙ УУРХАЙ”-Н
2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

/АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСТАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-012199/
/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 2095025/

Хянасан:

БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын ахлах шинжээч

Хэрэгжилтийг гаргасан:

“Монголын Алт” (МАК) ХХК-ний
Үйлдвэр Техникийн Газрын захирал



[Handwritten signature]

/Д. Баярсайхан/

Байгаль орчны мэргэжилтэн

/А. Халиунаа/

2022 он

Гарчиг

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	5
Компанийн танилцуулга	5
Компанийн байгаль орчны бодлого:.....	5
ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ГАЗРЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	6
Ордын ерөнхий мэдээлэл, байршил:.....	6
Дэд бүтэц:	7
Зам тээврийн нөхцөл:	7
Уурхайн жилийн хүчин чадал:	7
Ажиллах хүчний мэдээлэл:.....	7
Уурхайн нүүрс олборлолт болон тээвэрлэлт:	7
Уурхайд ашиглагдаж буй техник тоног төхөөрөмж	7
Уурхайн барилга байгууламж:	8
Уурхайн цахилгаан хангамж:	8
Уурхайн усан хангамж:.....	9
Унд ахуйн ус:	9
Шүүрлийн ус:.....	9
Ундны ус:	10
УУРХАЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	11
Агаарын чанарт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл	11
Хөрсний чанарт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл.....	11
Усны чанарт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл	11
Амьтан, ургамлын зүйлийн бүрдэлд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл.....	11
2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛГО, ЗОРИЛТ	12
БҮЛЭГ 1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	13
1.1. Агаар орчныг хамгаалах чиглэлээр хийгдсэн ажлууд	13
1.2. Усан орчинг хамгаалах чиглэлээр хийгдсэн ажлууд:	19
1.3. Хөрсний эвдрэл, элэгдэлд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр.....	21
1.4. Ургамлан бүрхэвч, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр	26
БҮЛЭГ 2. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	29
БҮЛЭГ 3. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	31
БҮЛЭГ 4. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	33

БҮЛЭГ 5. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 33	
БҮЛЭГ 6. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	34
БҮЛЭГ 7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	40
БҮЛЭГ 8. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	46
8.1. Усны чанарын хяналт шинжилгээ	46
8.2. Хөрсний хяналт шинжилгээ	48
8.3. Агаарын хяналт шинжилгээ	51
8.4. Амьтны аймгийн хяналт шинжилгээ	53
8.5. Ургамлын судалгаа	54
8.6. Дуу шуугианы хяналт шинжилгээ	55
БҮЛЭГ 9. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	57
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЗАРЦУУЛСАН НИЙТ ЗАРДАЛ	61
ДҮГНЭЛТ	62
ХАВСРАЛТ МАТЕРИАЛУУДЫН ЖАГСААЛТ	63

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Компанийн танилцуулга:

“Монголын Алт” (МАК) ХХК нь 1993 онд үүсгэн байгуулагдсан, үндэсний хөрөнгө оруулалттай, Монгол улсын тэргүүлэх компаниудын нэг билээ. Манай компани уул уурхай, барилгын материал төсөл, хөдөө аж ахуй, агаарын тээвэр, үл хөдлөх хөрөнгө, хэвлэл мэдээлэл зэрэг чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Үйл ажиллагааныхаа туршид улс, орон нутгийн төсөвт татвар төлөлтөөрөө тогтмол тэргүүлж ирсэн бөгөөд байгаль орчинд сөрөг нөлөө багатай, дэлхийд тэргүүлэх сүүлийн үеийн дэвшилтэт техник технологийг үйл ажиллагаа, үйлдвэрлэлдээ нэвтрүүлж, улс эх орныхоо хөгжил, эдийн засагт бодитой хувь нэмэр оруулах томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг билээ.

“Монголын Алт” (МАК) ХХК-ийн Хөх цав цемент-шохойн үйлдвэрийн төсөл болон дагалдах уурхайнуудын үйл ажиллагааг хариуцан хэрэгжүүлэхээр 2014 оны 04-р сарын 16-нд “МАК ЦЕМЕНТ” ХХК байгуулагдсан бөгөөд Хөөтийн уурхайн үйл ажиллагааг хариуцдаг.

Компанийн байгаль орчны бодлого:

Бидний эрхэм зорилго: Компанийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн бүхий л үе шатанд байгаль орчинд үүсч болох аливаа сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах талаар анхааран ажиллах, байгалийн нөөцийг удаан хугацаанд тогтвортой ашиглах нь компанийн нэн тэргүүний зорилго юм.

Бидний дээдлэх үнэт зүйлс: Компани ба түүний салбар нэгжүүд нь үйлдвэр, уурхайн төслийг боловсруулах шатнаас үйл ажиллагааныхаа бүх хүрээнд байгаль орчны асуудлыг байнга анхаарч Монгол улс болон олон улсын хэмжээнд мөрдөж буй уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны холбогдолтой хууль, журам, гэрээ хэлэлцээрийг дагаж мөрдөнө. Эх орон, төрсөн нутаг, усаа хайрлан хамгаалах нь компанийн бүх ажилчид албан хаагчдын үнэт зүйл болох учиртай.

Баримтлах бодлого: Манай компани нь дараах зорилтуудыг дэвшүүлж ажилладаг. Үүнд:

- Байгалийн нөөц баялгийг урт удаан хугацаанд тогтвортой, үр ашигтай зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар баримталж ирсэн төрийн бодлогыг хэрэгжүүлж, эрх бүхий байгууллагаас баталсан байгаль орчны стандарт, хэм хэмжээ, дүрэм журмыг чанд сахин биелүүлж, дотоодын болон хөндлөнгийн байгаль орчны хяналтыг тогтмол гүйцэтгэх;
- Улсын болон орон нутгийн хэмжээнд тогтвортой үйл ажиллагаа явуулдаг байгаль орчныг хамгаалах чиглэлийн төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах;
- Олон улсын байгаль орчны байгууллагууд болон байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи бүхий туршлагатай компаниудтай хамтран ажиллаж, улмаар олон улсын байгаль орчны стандартуудыг өөрийн үйлдвэрлэл, үйл ажиллагаанд нэвтрүүлэх;
- Үл нөхөн сэргээгдэх байгалийн нөөц баялгийг ариг гамтай, хаягдалгүй технологи болон дахин боловсруулах аргаар ашиглах;
- Байгалийн нөөцийн ашиглалтын үр ашгийг өндөр түвшинд байлгах зорилгоор тогтмол судалгаа шинжилгээг явуулж орчин үеийн үр ашигтай техник, технологийг үйлдвэрлэлдээ тууштай нэвтрүүлэх;

- Үйлдвэрлэл, уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн иргэдийн соёл, өв уламжлалыг хүндэтгэн хамгаалах, тэдний биет өв, ёс заншлын талаархи мэдээлэл, тэдгээрийн ач холбогдлыг компанийн ажилчдад тогтмол таниулах;
- Өөрийн компанийн байгаль орчны талаар баримтлах бодлого зарчмыг хамтран ажиллаж буй түнш, гэрээт гүйцэтгэгч нарт зааж таниулах, тавих шаардлагыг өндөржүүлэх замаар байгаль орчны чиглэлээр тэдний хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэх зэрэг болно.

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ГАЗРЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Ордын ерөнхий мэдээлэл, байршил:

Хөөтийн нүүрсний орд нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт Говь Угтаал-Баянжаргалангийн өндөрлөгийн төв хэсэгт тогтсон Хөөтийн хотгорт оршино. Ордын тусгай зөвшөөрлийн MV-12199, MV-020297 талбайнуудын газарзүйн солбилцол:


Хүснэгт 1: Ордын газарзүйн солбилцлүүд

№	Уртраг	Өргөрөг	№	Уртраг	Өргөрөг
1	107° 40'00"	45° 41'30"	3	107°44'00"	45° 40'00"
2	107° 44'00"	45° 41'30"	4	107°40'00"	45° 40'00"

Хөөтийн нүүрсний орд ба хот суурин газрууд, бусад объектуудын байршил:

Хүснэгт 2: Бусад байршил хоорондын зай

№	Хот, суурин газрын нэр	Ордын байршил	
		Зүг	Зай [км]
1	Улаанбаатар хот	Зүүн урагш	300
2	Чойр	Баруун урагш	100
3	Мандалговь	Зүүн хойш	130
4	Баянжаргалан сум Арагтай	Баруун тийш	26



Зураг 1: Хөөтийн нүүрсний ордын байр зүйн зураг

Дэд бүтэц: Хөөтийн нүүрсний орд нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос зүүн урагш 300 км, төмөр замын зангилаа бүхий Чойр хотоос баруун урагш 100 км, аймгийн төв Мандалговь сумаас зүүн хойш 130 км, Баянжаргалан сумын төв Арагтайгаас баруун тийш 26 км зайд Хөөтийн хотгорт оршино.

Зам тээврийн нөхцөл: Орд нь бүтэн жилийн турш бусад хот сууринтай зам тээврээр холбогдох боломжтой бөгөөд Улаанбаатар хотоос төмөр замын Чойр өртөө болон Говь- Сүмбэр аймгийн төв хүртэл асфальтан замаар, цааш Говь-Сүмбэр аймгийн төвөөс орд хүртэл шороон замаар холбогдоно.

Уурхайн жилийн хүчин чадал: Техник эдийн засгийн үндэслэлийн дагуу ашиглалтыг явуулж 2022 оны уулын ажлын төлөвлөгөөгөөр 1160 метрийн түвшин хүртэл гүнзгийрч нийт 1013 мян.м³ хөрс хуулж, 620 мян.тн нүүрс олборлох зорилттой ажиллаж байна.

Уурхайн ажиллах горим: 2022 онд Хөөтийн уурхайн ажиллах горим дараах байдлаар үйл ажиллагаагаа явуулж байна:

Хүснэгт 3: Уурхайн ажиллах горим

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээ	Тайлбар
1	Жилийн ажлын горим	Тасралтгүй		
2	Жилийн календарьт хугацаа	хоног	365	
3	Жилд ногдох ажлын бус хоног	хоног	30	Баяр ёслол
4	Цаг агаарын саатал хүндрэл	хоног	5	
5	Жилд ажиллах хоног	хоног	277	
6	Хоногийн ажлын горим	ээлж	2	
7	Ээлжийн хугацаа	цаг	12	

Ажиллах хүчний мэдээлэл: 2022 оны Хөөтийн уурхайн батлагдсан бүтэц орон тоо нь 126 бөгөөд үүнээс нэг ээлжинд 30-35 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Уурхайн нүүрс олборлолт болон тээвэрлэлт: 2022 онд 1,013мян.м³ хөрс хуулалтын ажлыг экскаватор ухаж ачих ажлыг хийж гүйцэтгэж, нүүрсний давхаргуудын дундах нимгэн чулууны үет давхаргыг САТ-374 экскаватор цэвэрлэн ачна. САТ-374 экскаваторын ажлын талбайн хамгийн бага өргөнийг HOWO-371 маркийн 52 тн-ын автосамосвалтай хослохоор тооцоолон ажлын талбай бэлэн болмогц дараагийн түвшинд шилжин ажиллах горимоор үргэлжилж байна.

Уурхайд ашиглагдаж буй техник тоног төхөөрөмж: 2022 онд уурхайн ажилд хэрэглэгдэж буй тоног төхөөрөмжүүдийг хүснэгт 4-т үзүүлэв.

Хүснэгт 4: Уурхайд ажиллаж буй техникуудийн жагсаалт

Техникийн төрөл	Марк	Хүчин чадал	Уурхай дээр байгаа тоо ширхэг	Ажлын зориулалт
Экскаватор	Hyundai-850	5м ³	1	Хөрс хуулалт
Экскаватор	САТ-374	5м ³	1	Хөрс хуулалт болон нүүрс олборлолтонд ачилт хийх
Автосамосвал	Howo-371	50тн	3	Хөрс болон цэвэрлэгээ тээвэрлэх
Белаз	76473	32тн	1	Зам талбай усалж тоосжилтыг бууруулах

Бульдозер	CAT D9R	18.5м ³	1	Шимт хөрс хуулалт, ул таазны цэвэрлэгээ болон овоолгын ажилд
Автогрейдер	CAT 160H		1	Овоолго, зам болон мөргөцгийг тэгшлэх
Автосамосвал	North Benz	100тн	2	Нүүрс тээвэрлэлт
Автосамосвал	Howo 420	80тн	6	Нүүрс тээвэрлэлт
Автосамосвал	Howo 420	тн	6	Нүүрс тээвэрлэлт

Дээрх уулын ажлын зориулалттай техникүүдээс гадна түлшний хангамжинд хэрэглэх түлшний тэрэг болон олон төрлийн үйлчилгээний зориулалттай ачигч, галын машин, механик засварын машин зэрэг машин, тоног төхөөрөмжийг уурхайн бусад хэрэглээнд ажиллаж байна.

Уурхайн барилга байгууламж: Төслийн талбайд дараах барилга байгууламжууд байна:

- Ажилчдын түр хотхон / амрах байр
- Оффис, сургалтын өрөө
- Зоогийн газар
- Халуун ус, хувцас угаалгын байр
- Хөөт 35кВ дэд станц, КТПН
- Засвар үйлчилгээний хэсэг-хаягдал тосыг түр хадгалах цэг
- ШТМ-ын агуулах
- Сэлбэг хэрэгслийн агуулах
- Насосчны байр
- Авто-пүү
- Зөөврийн шатахуун түгээгүүр
- Хог хаягдлыг ангилан ялгаж түр хадгалах цэг

Уурхайн цахилгаан хангамж: Шивээ-Говь 35кВ ЦДАШ нь Хөөтийн уурхайгаас 26км зайд байрлах Баянжаргалан сумын 35/15/10кВ дэд станцыг тэжээнэ. Үүнээс Хөөтийн уурхайн 35/6 дэд станц нь 3 гаралттай тэжээгдэж уурхайн засвар үйлчилгээний төв, ажилчдын хотхон болон зэрэгцээ үйл ажиллагаа явуулдаг Биг Могул уурхайг тус тус цахилгаан эрчим хүчээр хангаж байна.



Зураг 2: Хөөтийн уурхайн цахилгаан дамжуулах 35кВ дэд станц

Уурхайн усан хангамж: 2022 онд Хөөтийн нүүрсний уурхай нь 20-25м гүнтэй ус муу агуулдаг нүүрслэг аргиллит, алевролит, аргиллит зэрэг тунамал чулуулгийг хамарч уулын ажлыг явуулсан бөгөөд шүүрэн орох усны ундарга харьцангуй бага 0.2-0.8л/с бөгөөд ил зумпфын аргаар хоногт дунджаар 250м³ ус таталтын ажлыг цаг тухай бүрт нь явуулан ажиллаж байна. Ус цуглуулах зумпфыг уурхайн ёроолд ахилт багатай талд байрлуулан усыг цуглуулж 1Д-315-71 маркын насосоор соруулан зам талбайн тоосжилтыг дарах зорилгоор зам усалгааны ажилд болон ногоон байгууламж услахад ашиглав.

Унд ахуйн ус: Уурхайн унд ахуйн усыг 26км зайд байрлах Баянжаргалан сумын гүний худгаас 5тн-ы усны маяги ашиглан зөөврөөр хангадаг байсан бөгөөд 7 дугаар сараас эхлэн уурхайгаас 10км зайд гаргасан цооногийг ашиглалтанд оруулж уурхайн унд ахуйн хэрэглээнд ашиглаж эхлээд байна.




Зураг 3: Цооногийг ашиглалтанд оруулах үеийн фото зургуудаас

Дээрх худгийн цооногийг Дундговь аймгийн БОАЖГ-ын 2021 оны А/04 зөвшөөрлийн дагуу малчин иргэн Г. Мөнхдалайн хэрэглээнд гаргаж өгсөн бөгөөд тайлант оны 7 дугаар сард худгийн байрыг барьж ашиглалтанд оруулсан.

Шүүрлийн ус: Уурхайн уулын ажил 3 дугаар сараас эхэлснээр сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагчийн орлогчийг байлцуулан уурхайгаас ус шавхан зайлуулах хэсэгт байршуулсан насост тоолуур суурилуулан шүүрлийн ус шавхан зайлуулах ажлыг эхлүүлсэн. Бид усны тухай

хуулийн 30.1.4 дэх заалтын дагуу уурхайн шүүрлийн усыг шавхан зайлуулах хэсэгт Стандарт хэмжилзүйн газраар баталгаажуулсан тоолуур суурьлуулсан бөгөөд сар бүр сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагчаар уурхайгаас шавхан зайлуулсан шүүрлийн усны хэмжээ, тоолуурын заалтыг хянуулан акт үйлдэж байна.

Доорх графикаас тайлант оны III сараас IX сарын турш шавхан зайлуулсан шүүрлийн усны хэмжээ болон шүүрлийн ус ашиглалтын хэмжээг харна уу.




Чарт 1: Шүүрлийн ус шавхан зайлуулсан хэмжээ ба түүний ашиглалт



Чарт 2: Шүүрлийн ус шавхан зайлуулсан хэмжээ ба нийт эргүүлэн ашигласан хэмжээ

Ил зумфпны гүн нь 1.5м, өргөн нь 2.5м бөгөөд дээр дурдагдсан усны насосаар соруулж 32тн-ы Белазаар 16м өргөнтэй, 1.0-2.5км урт ил уурхайн доторх зам болон уурхайгаас овоолго хүрэх зам талбайг өдөрт 1-2 рейсээр 7 хоногт 3-7 удаагийн давтамжтайгаар усалж тоосжилтыг дарсан. Тайлант оны III-IX сарын хооронд нийт 52,129м³ ус шавхан зайлуулсан бөгөөд үүнээс 2,560тн-ыг зам усалгаанд, 799тн-ыг ногоон байгууламж услахад нийт 3,359тн буюу шавхан зайлуулсан усны 6%-г эргүүлэн ашигласан байна.

Ундны ус: Хөөтийн хотгорын хэмжээнд хийсэн хайгуулын өрөмдлөгийн цооногт гүний ус илэрдэг боловч эрдэсжилт ихтэй тул ундны болон техникийн хэрэгцээнд ашиглахад тохиромжгүй. Иймээс дээр дурдсан уурхайгаас 10км зайд байрлах малчны худгаас унд ахуйн усыг зөөврөөр хангаж байна.



Чарт 3: Уурхайн унд ахуйн усны хэрэглээ

Дээрх граф-д үзүүлсэнчлэн уурхайн унд ахуйн хэрэглээнд сард дунджаар 60тн ус хэрэглэж байна.

УУРХАЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Агаарын чанарт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл

Уурхайн үйл ажиллагаанаас агаар мандалд үзүүлэх сөрөг нөлөөлөл нь тоосжилт, хорт хий, утаа, нүүрсний тоосонцор байж болох юм. Уурхайн байрлаж буй хэсэг нь хуурай уур амьсгалтай, салхи шуурга ихтэй, говь цөлийн бүс бөгөөд ургамлан бүрхэвч тачир сийрэг, нимгэн давхаргатай хөрс тул тоосжилт ихээр үүсэх боломжтой юм. Хөрс хуулалт, хөрсний догол, мөргөцөг гаргах, мөн олборлолт хийх зэрэг ажлууд хийх явцад агаарт үүсэх их хэмжээний тоос, салхи, шуургаар дамжин тархалт ихэснэ. Говийн нөхцөлд салхины хурдны давтагдал их байдаг нь ордын үйл ажиллагааны нөлөөгөөр газрын хөрснөөс суларсан шороо хийсч агаар бохирдуулах нь ихсэж болзошгүй юм.

Хөрсний чанарт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл

Хөөтийн уурхай орчмын хөрс нь шим тэжээлийн түвшингээр тааруу, ялмагийн агууламж бага 0.24-2.96 %, элсэнцэр, элсэрхэг хөнгөн механик бүрэлдэхүүнтэй учир элэгдэл эвдрэлд орохдоо амархан хөрс юм. Уулын малталт, олборлолтын ажлын талбайг бэлтгэх, зам шинээр гаргах зэрэг хөрсний өнгөн хуулалт хийх, газар шорооны ажлыг эхлүүлэх үйл ажиллагаатай холбоотойгоор хөрс эвдэрч элэгдэлд орно. Уурхайд ашиглагдаж байгаа хүнд машин механизмын хөдөлгөөн, түрэлтээр орчны хөрсний үе давхаргууд гэмтэж, бороо хур ихтэй үед хөрсөн дээр хонхор үүсч хөрс эвдрэх магадлалтай.

Усны чанарт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл

Усны эх үүсвэр болох худгийн ойр орчимд гүний усыг бохирдуулах үйл ажиллагаа явуулах, урсгалын эхэнд ус бохирдуулах үйл ажиллагаа явуулах (машин угаах, үйлдвэрийн болон ахуйн хог хаягдал хаях), шатах тослох материал хөрсөнд асгарах зэрэг нь хөрсний сул ус болон хур тунадсаар дамжиж ундны ус цаашлаад гүний усыг бохирдуулж болзошгүй.

Амьтан, ургамлын зүйлийн бүрдэлд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл

Хөрс хуулалт болон тэсэлгээ, нүүрс тээврийн үйл ажиллагаатай холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэлд орж ургамлан нөмрөг, тэжээллэг ашигт ургамлын зүйл буурах аажмаар алга болох эрсдэлтэй. Нүүрс олборлолт, тээврийн үед их хэмжээгээр тоосонцор агаарт дэгдэх үед

нарны цацрагийн шууд тусгалыг хаах түүний нөлөөгөөр ургамлын ургалт багасч анхдагч бүтээгдэхүүний бүтээмж буурах магадлалтай. Буурсан тохиолдолд идэш тэжээлийн гинжин хэлхээнд өөрчлөлт орох, амьтад идэш тэжээлээ даган нүүдэллэх тухайн нутгаас даажих, хэрвээ идэш тэжээлээр дамжин хүнд металл болон химийн хорт нэгдлүүд амьтны биед орсон тохиолдолд тэдгээрийн генийн санд өөрчлөлт орох гэх мэт эрсдэл гарч болзошгүй юм.

2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Дундговь аймгийн Баянжаргалан суманд орших Хөөтийн нүүрсний ил уурхайн Байгаль орчны менежмент төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсруулахдаа БОАЖЯ-ны сайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А-618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежмент төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримтлав. Түүний дагуу тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын биелэлтийг нэг бүрчлэн тодорхойлж, хөрөнгө зардлыг тооцсон бөгөөд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлтийн хэсэгт хяналт шинжилгээний ажлын үр дүнг дэлгэрэнгүй хэлбэрээр тусгасан болно. Хөөтийн уурхайн үйл ажиллагаа 2022 оны 3 сараас эхлэн одоог хүртэл тасралтгүй явагдаж байна.

2022 оны Хөөтийн уурхайн Байгаль орчны менежмент төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлсэн гол үйл ажиллагаанууд, түүний үр дүнг дурдвал:

- “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийг дэмжих, мөн уурхайн үйл ажиллагаанаас үүсч болзошгүй ургамлан нөмрөгийн талхалалт болон тоосжилтыг бууруулах зорилгоор уурхайн хотхоны гадна болон дотоод талбайд 7 төрлийн нийт 1044 ширхэг мод тарьсан.
- Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Баянжаргалан сумын “Аргийн хад” хэмээх орон нутгийн тусгай хамгаалалттай газарт зэрлэг ан амьтдад зориулж бий болгосон нарны эрчим хүчээр ажилладаг уст цэгийн үр дүнг хянах, ан амьтныг бүртгэлжүүлж мониторинг хийх зорилгоор тус худгийн байр орчимд 2 ширхэг хяналтын камера, дагалдах материалын хамт суурьлуулан орон нутагт хүлээлгэн өгсөн.
- Хөөтийн уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг хянах, бууруулах зорилгоор агаарын чанар, газрын доорх ус, хөрсөн бүрхэвч зэрэг чиглэлээр орчны хяналт шинжилгээний ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд болон тэдгээрийн биелэлтийн тоон үзүүлэлтийг дараах хүснэгтэд нэгтгэн илэрхийлэв.

Хүснэгт 5: Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын биелэлтийг нэгтгэсэн тоон үзүүлэлт

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төрөл	Нийт төлөвлөгдсөн ажлын тоо	Гүйцэтгэл	Хийгдэж буй болон хойшлогдсон ажлын тоо
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	14	14	-
2	Нөхөн сэргээлт	1	1	-
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	1	1	-
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ	1	-	1
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ	1	1	-
6	Осол эрсдлийн менежмент	5	5	-
7	Хог хаягдлын менежмент	4	4	-
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	13	13	-
9	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	8	7	-
10	Олон нийтэд тайлагнах үйл ажиллагаа	3	3	-

Дээрх хүснэгтээс үзэхэд энэ оны Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд 10 бүлэг чиглэлээр нийт 51 ажил хийгдэхээр тусгагдсанаас одоогоор 96%-ийн биелэлттэй байна. Нөлөөллийн бүсийн өрхийг нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох ажлыг удирдлагад танилцуулж шийдвэрлэх чиглэл авсан бөгөөд тухайн өрхийг гомдолгүй болгох арга хэмжээний хувилбаруудыг бэлдэж байна.

БҮЛЭГ 1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

1.1. Агаар орчныг хамгаалах чиглэлээр хийгдсэн ажлууд

Зорилго: Уурхайн ажилчдын эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцлийг бүрдүүлэх, хүрээлэн буй орчны тэнцвэрт байдлыг хадгалах зорилгоор орчны агаар дахь хими, физикийн гаралтай түгээмэл бохирдуулагчийг стандарт хэмжээнээс хэтрүүлэхгүй байхад оршино.

Хүснэгт 6: Агаар орчинд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээний биелэлт

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Биелэлтийн шалгуур	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал
1	Уурхайн хэмжээнд ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх	Уурхайн хэмжээнд	Жилдээ	Уурхайн хотхоноос урагш замын хажуу талаар болон хотхоны өргөтгөл хэсгээр ногоон байгууламжийг нэмэгдүүлж мөн нөхөн тарилт хийсэн	10,265.0
2	Тоосжилтыг бууруулах зорилгоор тогтмол зам усалгаа хийх	Уурхайн дотоод технологийн зам	Тухай бүрт	Замын тоосжилтыг бууруулах зорилгоор уурхайн технологийн зам болон карьерт 32тн усны Белазаар өдөрт 1-4 рейсээр 7 хоногт 3-7 удаагийн давтамжтайгаар усалгаа хийж ажилласан	Үйл ажиллагааны зардлаас
3	Хурд хязгаарлах тэмдэг тэмдэглэгээг сайжруулан мөрдүүлж ажиллах	Уурхайн дотоод технологийн зам талбай	Тухай бүрт	Уурхайн дотоод замын тэмдэг, тэмдэглэгээ, ойлгогчийг сайжруулсан бөгөөд хурдны хязгаарлалтыг мөрдүүлэн ажиллаж байна.	Үйл ажиллагааны зардлаас
4	Нүүрс тээврийн жолоочид бүтээлгээ бүрэн хучсан эсэхэд хяналт, шаадлага тавьж ажиллах	Уурхайн дотоод технологийн зам	Тухай бүрт	Нүүрс тээврийн машины бүтээлгийн бүрэн бүтэн байдлыг хянаж, жолоочид бүрэн зохистой хучиж байх шаардлагыг тавьж, уурхайд мөрдөх журмыг мөрдүүлж ажиллаж байна.	Үйл ажиллагааны зардлаас
5	Автотээврийн хэрэгсэлд ногдох агаарын бохирдлын төлбөрийг агаарын бохирдолын төлбөрийн тухай хуульд заасан хувь, хэмжээгээр төлөх	Уурхайн хэмжээнд	6 дугаар сарын 1-нээс өмнө	БОАЖ-ын сайд Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын 2011 оны А/63/67 дугаар хамтарсан тушаалын хавсралтаар батлагдсан журмын дагуу уурхайн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа ихэвчлэн том оврын буюу Е ангиллын техник	133,0

				хэрэгслүүдийг нэгж км зай туулахад 751 гр-аас их нүүрстөрөгчийн хий ялгаруулна гэж тооцон төлбөрийг тээврийн хэрэгсэл бүрт 9,500.0 төгрөгөөр бодож, татварын албанд төлсөн.	
6	Уурхайн дотоод болон гадаад овоолгод үүсэх уугилт, шаталтыг тухай бүрт нь унтраах арга хэмжээ авч ажиллах	Уурхайн овоолго	Тухай бүрт	Хөрсний овоолгоос үүсэх уугилт, шаталтыг тухай бүрт нь унтрааж байна.	Үйл ажиллагааны зардлаас
Нийт					10,398.0

1.1.1. Уурхайн хэмжээнд ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх

Тайлант оны V сард буйлс, тэхийн шээг, жигд, сухай, улиас, хайлаас болон шар хуайс гэсэн 7 төрлийн мод бутыг уурхайн хотхоноос урагш замын хоёр талаар, хотхоны өргөтгөл болон хотхоны дотоод талбайд шинээр болон нөхөн тарилт хийх байдлаар нийт 1044 ширхэгийг тарьсан байна. Мөн хотхоны 658.16м² талбайд олон настын үр тарьж зүлэгжүүлсэн.



Зураг 4: Хаврын тарилт хийх үеийн фото зургуудаас



Зураг 5: Олон наст ургамалын үр цацаж буй нь

1.1.2. Замын тоосжилтыг бууруулах зорилгоор усалгаа хийх

Замын тоосжилтыг бууруулах зорилгоор уурхайн технологийн зам болон уурхайн карьерт 32тн усны Белазаар өдөрт 1-4 рейсээр 7 хоногт 3-7 удаагийн давтамжтайгаар усалгаа хийв.



Зураг 6: Уурхайн технологийн зам усалгааны ажил хийгдэж байна

1.1.3. Тээврийн хэрэгслийн хурдыг хязгаарлах тэмдэг зааврыг мөрдөж ажиллах

Уурхайн дотоод замын тэмдэг, тэмдэглэгээг сайжруулсан бөгөөд хурдны хязгаарлалтыг мөрдүүлэн ажиллаж байна. Тайлант онд шинээр 35 ширхэг замын түмф, 4 ширхэг анхааруулах тэмдэг, 4 ширхэг заах тэмдэг, 4 ширхэг хориглох тэмдэг, 1 ширхэг байршил заах тэмдэг, 2 галын сараа иж бүрдэлийн хамт байршуулж, тохижуулсан. Мөн зөөврийн шатахуун түгээгүүрийг ашиглалтанд оруулж, тэмдэг тэмдэглэгээ, хаягжилтыг бүрэн хийсэн байна.



Зураг 7: Уурхайн тэмдэг тэмдэглэгээ хийсэн байдал

1.1.4. Тээврийн машины бүтээлгийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих

Уурхайн бүсэд баримтлах Байгаль орчны журмыг боловсруулан батлуулж уурхайд нэвтэрч буй нүүрс тээврийн машинуудын жолооч бүрт танилцуулан журмын дагуу хамтран ажиллахыг шаардаж байна.



ХӨӨТИЙН НҮҮРСНИЙ УУРХАЙ

БАТЛАВ: УУРХАЙН ДАРГА



В. БАТТУЛГА

**МАК ХХК-НИЙ ХӨӨТИЙН НҮҮРСНИЙ УУРХАЙД БАРИМТЛАХ БАЙГАЛЬ
ОРЧНЫ ЖУРМЫГ ГЭРЭЭТ КОМПАНУУДАД ТАНИЛЦУУЛАХ ТУХАЙ**

1. Нийтлэг үндэслэл

“Монголын Алт” (МАК) ХХК-ийн Ерөнхийлөгчийн 2021 оны 06 дугаар сарын 23-ний өдрийн А/383 тоот тушаалаар батлагдсан “Хог хаягдлын менежментийн журам”-ыг гэрээт компануудад танилцуулах, дагаж мөрдүүлэн хамтран ажиллахад оршино. Ингэснээр тус журамын зорилт болох Хог хаягдлын улмаас байгаль орчинд үзүүлж болох аливаа сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, ажилчдыг эрүүл аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх хог хаягдлын менежментийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндсэн нөхцөл бүрдэх юм.

2. Хөөтийн нүүрсний ил уурхайд мөрдөгдөх Байгаль орчны зааварчилгаа

- 2.1.1. Монгол улсын замын хөдөлгөөний дүрмийг мөрдөж, уурхайн бүсэд байрлуулсан тэмдэг тэмдэглэгээний дагуу хурдаа тохируулан явна.
- 2.1.2. Уурхайн бүсэд ил задгай хог хаяхгүй байх.
- 2.1.3. Яаралтай болон гэнэтийн техникийн засвар үйлчилгээ хийсэн тохиолдолд үүсэх Шатах тос материалыг хөрсөнд нэвчүүлэхгүйгээр саванд тосож битүүмжлэн авч явна.
- 2.1.4. Мөн хаягдал дугуйг уурхайн бүсэд ил задгай үлдээхгүйгээр ачиж явна.
- 2.1.5. Нүүрс ачилт хийж байх үед машинаас буухгүй байх (буусан тохиолдолд хамгаалалтын малгай өмсөх) бөгөөд ачилт хийж дуусмагц бүтээлгийг зохистой хучиж уурхайн карьераас гарна.

3. Үүрэг харилцаа

3.1. Гэрээт байгууллагын удирдлага:

- 3.1.1. Журмын хэрэгжилтэд дэмжж үзүүлэх
- 3.1.2. Үндсэн болон шинээр орж буй тээврийн жолоочид зааварчилгааг тогтмол танилцуулан бүртгэлийг ирүүлэх

3.2. Тээврийн жолооч:

- 3.2.1. Журмыг мөрдлөг болгож зааварчилгааг хэрэгжүүлэх
- 3.2.2. Уурхайн бүсэд харьяалагдах газарт их хэмжээний аюултай бодис асгарсан тохиолдолд тээврийн жолооч нь уурхайн байгаль орчны мэргэжилтний зөвлөмжийн дагуу нөлөөллийг бууруулах арга хэмжээ авах.

4. Харилцаа

- 4.1.1. Энэ журмын хэрэгжилтийг биелүүлээгүй, зөрчсөн жолоочид эхний удаад санажм өгнө.
- 4.1.2. Зааварчилгааг удаа дараа зөрчсөн тохиолдолд гэрээт байгууллагын удирдлагад албан бичгээр мэдэгдэх бөгөөд тухайн тээврийн жолоочийг тээвэр хийлгэхгүй байх хүртэлх арга хэмжээг авна.
- 4.1.3. Энэ журмыг зөрчсөний улмаас компанид болон бусдад хохирол учруулсан тохиолдолд холбогдох хохирлыг нөхөн төлүүлнэ.

Зураг 8: Уурхайн бүсэд баримтлах Байгаль орчны журам

Энэхүү журмын 2.1.5-т зааснаар нүүрс ачилт хийж дуусмагц бүтээлгийг зохистой хучиж уурхайн карьераас гарахыг тусгасан бөгөөд журмын хэрэгжилтэнд тогтмол хяналт тавьж ажиллаж байна.



Зураг 9: Нүүрс тээврийн машин бүтээлгэтэйгээр уурхайгаас гарч буй нь

1.1.5. Автотээврийн хэрэгсэлд ногдох агаарын бохирдлын төлбөрийг агаарын бохирдолын төлбөрийн тухай хуульд заасан хувь, хэмжээгээр төлөх

БОАЖ-ын сайд Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын 2011 оны А/63/67 дугаар хамтарсан тушаалын хавсралтаар батлагдсан журмын дагуу уурхайн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа ихэвчлэн том оврын буюу Е ангиллын техник хэрэгслүүдийг нэгж км зай туулахад 751 гр-аас их нүүрстөрөгчийн хий ялгаруулна гэж тооцон төлбөрийг тээврийн хэрэгсэл бүрт 9,500 төгрөгөөр бодож, татварын албанд төлсөн.

1.1.6. Уурхайн дотоод болон гадаад овоолгод үүсэх уугилт, шаталтыг тухай бүрт нь унтраах арга хэмжээ авч ажиллах

Хөрсний овоолгоос үүсэх уугиар шаталтыг даамжруулахгүйн улмаас тухай бүрт нь унтраах арга хэмжээ авч ажилласан.



Зураг 10: Дотоод овоолгоос үүссэн уугилтыг унтрааж байна

1.2. Усан орчинг хамгаалах чиглэлээр хийгдсэн ажлууд:

Зорилго: Уурхайн ажилчдыг эрүүл аюулгүй, ундны усны шаардлага хангасан усаар хангах, уурхайн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулахад оршино.

Хүснэгт 7: Усан орчинд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээний биелэлт

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Биелэлтийн шалгуур	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал
1	Усны тоолуурыг салгах, суурилуулах тохиолдолд сумын байгаль орчны мэргэжилтэнг байлгах	Усны эх үүсвэр	Жилийн турш	Шүүрлийн ус шавхан зайлуулах хэсэгт байршуулсан насосны тоолуурыг салгах, суурьлуулах бүрт сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагчийн орлогчийг байлцуулсан	148,900

1.2.1. Усны тоолуурыг салгах, суурилуулах тохиолдолд сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагчийн орлогчийг байлгах

2022 оны төлөвлөгөөний дагуу III сараас уурхайн уулын ажил эхэлснээр 2022.03.19-ны өдөр шүүрлийн усны 201801044 маркийн 160м³ цагийн хэмжих хязгаартай 150мм голчтой, №004802 дугаар лацтай, 000017 заалттай тоолуурыг Баянжаргалан сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагчийн орлогчийг байлцуулан суурьлуулж акт үйлдсэн. Тухайн тоолуурт эвдрэл гарсны улмаас VIII сарын 09-ны өдөр мөн сумын холбогдох ажилтанг байлцуулан тоолуурыг сольж суурьлуулсан.



Зураг 11: Шүүрлийн усны насос тоолуур суурьлуулж буй нь

1.3. Хөрсний эвдрэл, элэгдэлд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр

Зорилго: Уурхайн үйл ажиллагаанаас үүссэн хөрсний элэгдэл эвдрэл, бохирдлыг багасгах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, уурхайгаас хуулсан шимт хөрсний үржил шимийг алдагдуулахгүйгээр хадгалах, арчлах.

Хүснэгт 8: Хөрсөнд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээний биелэлт


№	Сөрөг нөлөөллийг арилгах,	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Биелэлт ийн шалгуур	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал
---	---------------------------	-------------------------------	---------------------	-----------------	-------------

	бууруулах арга хэмжээ				
1	Үүсч болзошгүй ШТМ, нүүрс асгаралтанд арга хэмжээ авч цэвэрлэх, хяналт тавих	Төслийн талбай, уурхайн гадаад дотоод технологийн зам	Тухай бүрт	Уурхайн үйл ажиллагааны явцад үүсэх ШТМ-ыг уурхай дээр зохих байдлаар түр хадгалан Дорноговь аймгийн Даланжаргалан суманд байрлах “МАК Цемент” үйлдвэрт хүргүүлдэг. МАК Цемент нь “Алтан оршихуй” компанид ШТМ нийлүүлэх гэрээтэй билээ. Гэнэтийн байдлаар тохиолдох техникүүдийн эвдрэлээс шалтгаалж үүсэх ШТМ-д хяналт тавьж, яаралтай арга хэмжээ авч бүртгэл хөтөлдөг болно.	Үйл ажиллагааны зардлаас
2	Олборлолт болон бусад ажлын явцад өртөх талбайн шимт хөрсийг хуулан стандартын дагуу шимт хөрсний овоолгийг хадгалах	Уурхайн ахилтын талбай	Тухай бүрт	Хөөтийн уурхай нь газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалтыг MNS 5916:2008 стандартын дагуу гүйцэтгэж, шимт хөрсний овоолго үүсгэсэн. Уурхайн тэлэлт явагдахаас өмнө хөрсний үе давхаргын зузааныг тодорхойлж, дунджаар 20-40 см хүртэлх шимт хөрсийг хуулж хадгалан, чанарын хяналт хийж гүйцэтгэв.	Үйл ажиллагааны зардлаас
3	Уурхайн дотоод, гадаад зам талбайн хөрс суларсан тохиолдолд автогрейдэрээр хусаж, суларсан шороог түрж хашлага хийх	Уурхайн хэмжээнд болон Баянжаргалан сум хүртэлх тээврийн зам	Тухай бүрт	Уурхайн дотоод зам талбай болон нүүрс тээврийн замыг тогтмол хусаж сайжруулах ажлыг хийж гүйцэтгэсэн.	Үйл ажиллагааны зардлаас
4	Газар хөндөх зөвшөөрлийг тухай бүрт авч ажиллах	Төслийн талбайд	Жилийн турш	Манай уурхай 2022.10-р сарын байдлаар нийт 3.2га талбайд ахилт хийсэн бөгөөд газар хөндөх бүрт	Үйл ажиллагааны зардлаас

				зөвшөөрлийн хуудас авч ажилладаг.	
--	--	--	--	--------------------------------------	--


**1.3.1. Олборлолт болон бусад ажлын явцад өртөх талбайн шимт хөрсийг хуулан
стандартын дагуу шимт хөрсний овоолгийг хадгалах**

Хөөтийн уурхай нь газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалтыг MNS 5916:2008 стандартын дагуу гүйцэтгэж, шимт хөрсний овоолго үүсгэсэн. Уурхайн тэлэлт явагдахаас өмнө хөрсний үе давхаргын зузааныг тодорхойлж, дунджаар 30-50 см хүртэлх шимт хөрсийг хуулж хадгалан, чанарын хяналт хийж гүйцэтгэв.



Зураг 12: Шимт хөрсийг тусгайлан хуулж, овоолго үүсгэсэн байдал

Тайлант онд нийт 32,793 м² талбайд газар хөндөлт хийгдсэн байна. Үүнээс 24,715м² талбайд уулын ажлын ахилт явагдаж, 4031м² талбай нүүрс цагаалах судалгааны ажилд ашиглагдсан бол зам өргөтгөх зориулалтаар 4047м² талбайд тус тус газар хөндөлт хийсэн байна.



Зураг 13: Уурхайн карьер, хөрс болон шимт хөрсний овоолго

1.3.2. Уурхайн дотоод, гадаад технологийн зам дээр асгарсан нүүрсийг тухай бүрт цэвэрлэх

Нүүрс тээврийн машины жолооч нарт уурхайн карьерт бүтээлгээ бүтээж гарахыг шаардан ажилладаг. Хэрэв уурхайн дотоод технологийн замд нүүрсний бохирдол үүсвэл тухай бүрт нь жолоочоор цэвэрлүүлэх арга хэмжээ авдаг бөгөөд бөгөөд уурхайн гадаад зам дагуух асгаралтыг шалгаж, цэвэрлэгээ хийдэг болно.

1.3.3. ШТМ-ын асгаралтад хяналт тавих, бүртгэх

Уурхайн үйл ажиллагааны явцад үүсэх ШТМ-ыг уурхайн засвар үйлчилгээний төвийн гадаах талбайд зохих байдлаар түр хадгалан Дорноговь аймгийн Даланжаргалан суманд байрлах МАК Цемент-шохойн үйлдвэрт хүргүүлдэг. МАК Цемент нь компанид “Аюултай хог хаягдал нийлүүлэх гэрээ”-ний дагуу төвлөрсөн ШТМ-ыг нийлүүлдэг гэрээт компанид нийлүүлдэг.



Зураг 14: Ослын зумпф бүхий хаягдал тос хадгалах цэг

Гэнэтийн байдлаар тохиолдох техникүүдийн эвдрэлээс шалтгаалж үүсэх ШТМ-ын асгаралтад хяналт тавьж, зөрчил гарсан тохиолдолд сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг яаралтай авч бүртгэл хөтөлдөг болно.

Тайлант онд төслийн талбайд нийт 6 даагийн асгаралт үүссэн. Бохирдсон хөрсийг *Lactobacillus plantarum*, *Lactobacillus casei*, *Streptococcus*, *Saccharomyces cerevisiae*, *Candida utilis*, *Rhodopseudomonas palustris*, *Rhodobacter sphaeroides*, *Streptomyces cerevisiae*, *Streptomyces geiseus* зэрэг 80-100 төрөл зүйлийн ашигтай бичил биетэнг агуулдаг EM-1 бодисыг ашиглан хатуу хучилттай талбайд саармагжуулсан.



Зураг 15: Асгаралт үүссэн хөрсийг хатуу хучилттай талбайд саармагжуулах процесс

1.3.4. Уурхайн гадаад, дотоод зам талбайн хөрс суларсан тохиолдолд автогрейдэрээр хусч суларсан шороог түрж хашлага хийх

Уурхайн гадаад болон дотоод технологийн зам талбайн хөрс суларсан, эвдэрсэн тохиолдол бүрт автогрейдэрээр засаж хашлага хийдэг.



Зураг 16: Нүүрс тээврийн зам засварын ажил хийгдэж байна

1.3.5. Газар хөндөх зөвшөөрлийг тухай бүрт авч ажиллах

Уурхайн уулын ажлын төлөвлөгөөний дагуу 2022.10-р сарын байдлаар 32,793 м² талбайд ахилт хийсэн бөгөөд газар хөндөх бүрт зөвшөөрлийн хуудас авч ажилласан.

Байгаль орчны алба: Газрын менежмент
Засвар 12: Газар хөндөх зөвшөөрлийн хуудас
Үйлдвэр, уурхай:

Газар хөндөх зөвшөөрлийн хуудас

ХҮСЭЛТ ГАРГАГЧ БӨГЛӨНӨ:

- Газар шорооны ажлын байршил:**
 - уурхайн суурингийн эргэн тойрон
 - баяжуулах үйлдвэрийн орчим
 - уурхайн карьер
 - замын ажил
 - засварын цехийн талбай
 - хогийн цэг дээр
 - бусад /...../
- Хэлтэе, газар, гэрээт байгуулагын нэр:** /*Богдочин нүүрсний уурхай*/
- Газар хөндөх шалтгаан**
 - Өнгөн хөрс хуулах
 - уурхайн хөрс хуулах
 - хаалт хашаа бүрх
 - барилгын ажил
 - шинэ зам үүсгэх
 - хог/бохирын нүх ухах
 - хайрга, элсний карьер
 - бусад /...../
- Ажил эхлэх хугацаа:** /...../ **Ажил дуусах хугацаа:** /...../
- Газар хөндөх талбайн хэмжээ:** /*13739 м²*/
- Үйл ажиллагааны танилцуулга өгсөн эзэх / хавсаргах/**
 - төлөвлөгөө
 - газрын зураг
 - зураглал
 - гэрэл зураг
- Ажил дуусахад нохон сэргээлтийг хэрхэн хийх тухай мэдээлэл**
/...../

Хүсэлт гаргасан: /*В. Мунгалуу*/ Огноо: /*2022.04.01*/
Албан тушаал: /*У. Ганзориг*/ Огноо: /*2022.04.01*/
Уурхайн даргын гарын үсэг: /*[Signature]*/ Огноо: /*2022.04.01*/

Хөөтийн нүүрсний уурхайн газар хөндөх зөвшөөрлийн зураг

Зөвшөөрлийн дагуу газар хөндөлт хийгдэх талбай

Зураг 17: Газар хөндөх зөвшөөрлийн дагуу уулын ажил явагдсан

1.4. Ургамлан бүрхэвч, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр


Зорилго: Уурхайн орчны ургамлын зүйлийн бүрдлийг нэмэгдүүлэх, амьтны аймгийг хамгаалах уурхайн үйл ажиллагаанаас ургамал, амьтанд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулахад оршино.

Хүснэгт 9: Амьтан, ургамалд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээний биелэлт

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Биелэлтийн шалгуур	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал
1	Ургамлан бүрхэвчийн судалгаа хийж, мониторингийн арга хэмжээ авч ажиллах	Төслийн талбайн хэмжээнд	Жилд нэг удаа	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу 2022.07.26-ны өдөр уурхайн бүсийн MV-020297 болон MV-012199 лиценз талбайнуудад раменскийн тор ашиглан хийсэн.	Үйл ажиллагааны зардлаас
2	Биотехникийн арга хэмжээ авах	Бэлчээр нутгийн ан амьтад	Жилд 1 удаа	Ан амьтан хамгаалах, идэш тэжээлээр хангах зорилгоор Баянжаргалан сумын ЗДТГазарт 350 боодол өвс хүлээлгэн өгсөн болно.	4,500,000.0
Нийт					4,500,000

1.4.1. Ургамлан бүрхэвчийн судалгаа хийж, мониторингийн арга хэмжээ авч ажиллах

Уурхайн тусгай зөвшөөрлийн талбайд VII сард раменскийн тор ашиглан ургамлан нөмрөгийн судалгааг мониторингийн 2 цэгт хийж гүйцэтгэсэн. Ургамлан бүрхэвчийн судалгааны үр дүнтэй 8.5 хэсгээс танилцана уу.



Зураг 18: Ургамлан бүрхэвчийн судалгаа хийж буй явцаас

1.4.2. Биотехникийн арга хэмжээ

Ан амьтан хамгаалах, идэш тэжээлээр хомс улиралд ан амьтдыг өвс тэжээлээр хангах зорилгоор Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газарт III сарын 19-нд 150, IV сарын 20-нд мөн 300 боодол өвс нэмэлтээр хүлээлгэн өгсөн болно.



Зураг 19: Биотехникийн арга хэмжээ авч буй байдал

БҮЛЭГ 2. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Зорилго: Уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй эвдэрсэн хөрсний үржил шимийг эргүүлэн сэргээх, тухайн газрыг ургамалжуулах, амьдарч ажиллах таатай орчныг бүрдүүлэх, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх замаар төрөл бүрийн аж ахуйн чиглэлээр ашиглах боломжийг бүрдүүлэхэд оршино.

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Биелэлтийн шалгуур	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал
1	Шимт хөрсний овоолгод Биологийн нөхөн сэргээлт хийж ургамалжуулна	Төслийн талбай	Жилд нэг удаа	Уурхайн шимт хөрсний овоолгийн 2 га талбайд олон наст ургамал болох ерхөг, совооврийн үр цацаж ургамалжуулсан	1,200,000.0

Тайлант оны X дугаар сард уурхайн шимт хөрсний овоолгын 2,6га талбайд олон наст ургамалын болох ерхөг, согооврын үрээр биологийн нөхөн сэргээлт хийж ургамалжуулаад байна.



Зураг 20: Хөрс бэлдэж сийрэгжүүлж буй нь



Зураг 21: Олон наст ургамлын үр цацаж эхний усалгааг хийж байна

БҮЛЭГ 3. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Үйл ажиллагаа явуулж буй бүс нутгийн биологийн олон янз байдалд учирч болох сөрөг нөлөөллийг үе шаттайгаар бууруулах зарчмаар дүйцүүлэн хамгаалах дунд болон урт хугацааны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

Хүснэгт 10: Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд хийгдэхээр төлөвлөсөн ажлын биелэлт

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Арга хэмжээний цар, хүрээ	Биелэлтийн шалгуур	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал
1	Зэрлэг ан амьтдад зориулж бий болгосон уст цэгийн үр дүнг хянах, ан амьтныг бүртгэлжүүлж мониторинг хийх	“Аргийн хад” орон нутгийн ТХГ	Жилдээ	Баянжаргалан сумын Аргийн хад хэмээх орон нутгийн тусгай хамгаалалттай газарт зэрлэг ан амьтны усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор 2021 онд нарны зайн эх үүсгүүр бүхий хүний оролцоогүй цагийн тохируулгатай худаг байгуулсан билээ. 2022 онд энэхүү ажлын үр дүнг хянах, ан амьтны тоо толгойг бүртгэх зорилгоор тус худгийн байр орчимд 2 ширхэг хяналтын камер суурьлуулав.	2,800,000.0

3.1. Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд хийгдэхээр төлөвлөсөн ажлын биелэлт

Хөөтийн уурхай нь 2019 онд Дундговь аймгийн БОАЖГ-аас санал болгосон Баянжаргалан сумын “Аргийн хад” орон нутгийн тусгай хамгаалалттай газарт Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийлгэсэн билээ. Түүний дагуу уурхайн Байгаль орчны менежмент төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах 2020, 2021 оны дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд тус газарт зэрлэг ан амьтны усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор нарны эрчим хүчээр ажилладаг хүний оролцоогүй цагийн тохируулга бүхий худаг байгуулан сум орон нутагт хүлээлгэн өгсөн. Энэхүү ажлыг илүү үр дүнтэй болгож, сайжруулах зорилгоор 2022 оны дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд тус худгийн байр орчимд 2 ширхэг хяналтын камер, дагалдах материал (нэмэлтээр аккумулятор, нарны толь гэх мэт) -ын хамт суурьлуулж Байгаль хамгаалагч болон сумын ЗДТГ-т танилцуулан хүлээлгэн өгөөд байна.



Зураг 22: Нэмэлт нарны толь болон хяналтын камер суурьлуулах үеийн фото зураг

Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд хийгдсэн ажлын нийт зардлын задаргааг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 11: Дүйцүүлэн хамгаалах ажлын зардлын задаргаа

№	Системийн иж бүрдэл	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Шөнө өнгөтөөр хардаг гадаа камер	2	260,000	520,000
2	Бичигч төхөөрөмж	2	260,000	520,000
3	HRUI 4PORT POE Switch	1	100,000	100,000
4	Сүлжээний кабель	100	1,200	120,000
5	Хард диск	1	210,000	210,000
6	Нарны толь	1	2,640,000	2,640,000
7	Аккумулятор	4	320,000	1,280,000
8	Гүйцэтгэгч компани суурилуулалт, холболт болон тээврийн зардал	-		1,020,000
Нийт (НӨАТ-тай)				6,420,000

БҮЛЭГ 4. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Зорилго: Уурхайн нөлөөллийн бүсэд оршин суугчийн саналын дагуу иргэнийг нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох замаар гомдолыг барагдуулах, эрүүл мэнд, амьдралын чанарыг нь сайжруулах арга замыг эрэлхийлж, хэрэгжүүлэхэд оршино.

№	Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олох арга хэмжээний төлөвлөгөөний зорилт	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал
1	Уурхайн нөлөөллийн бүсэд оршин суух иргэний өргөдөл, хүсэлтийн дагуу нүүлгэн шилжүүлэх арга ажлыг зохион байгуулах	Нөлөөллийн бүс дахь өрх	Уурхайн нөлөөллийн бүсэд оршин суух иргэн Б. Ууганцэцэгийн хүсэлтийн дагуу нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ авах тухай удирдлагуудад танилцуулсан. Одоогоор эдийн засгийн газарт тооцоо судалгаа хийгдэх шатанд явж байна	-

БҮЛЭГ 5. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

5.1. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний хүрээнд хийгдсэн ажил

Зорилго: Уурхайн үйл ажиллагааны явцад санамсаргүйгээр археологи ба палеонтологийн олдворууд олдож болзошгүй тул үйл ажиллагааны явцад санамсаргүй олдворууд олдсон тохиолдолд Монгол улсын соёлын өвийг хамгаалах хууль болон компанийн “Санамсаргүй олдворын үед ажиллах журам”-ын дагуу дагаж мөрдөн ажиллах.

Хүснэгт 12: Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөний биелэлт

№	Нөлөөлөлд өртөх түүх соёлын өв	Арга хэмжээний цар хэмжээ	Биелэлтийн шалгуур	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал
1	Археологи палеонтологийн дурсгалт эд, өлгийн зүйл гэмтэх	Төслийн талбайд	Жилийн турш	Монгол улсын Соёлын өвийг хамгаалах хууль болон компанийн “Санамсаргүй олдворын үед ажиллах журам”-ыг дагаж мөрдөж ажилласан. Уурхайн нийт ажилчдад “Санамсаргүй олдворын үед ажиллах журам”-ын тухай сургалт орсон.	Үйл ажиллагааны зардлаас

5.1.1. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний биелэлт

Шинжлэх ухааны академийн түүх, угсаатан зүй, археологи, палеонтологийн хүрээлэнгээр Хөөтийн нүүрсний уурхайн MV-020297, 12199А дугаарын ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй 1443.73га, 1215.87га болон 0.066га 35 кв-ийн дэд станцын талбайнуудад

Археологи, палеонтологи, угсаатны зүйн судалгаануудыг 2012, 2020 онуудад гүйцэтгүүлсэн. 2022 онд уурхайн төслийн талбайгаас ямар нэг археологи палеонтологийн дурсгалт эд, өлгийн зүйлийн олдвор илрээгүй болно.

Тайлант онд Монгол улсын Соёлын өвийг хамгаалах хууль болон компанийн “Санамсаргүй олдворын үед ажиллах журам”-ыг дагаж мөрдөн ажилласан. Уурхайн нийт ажилчид болон шинээр орж буй ажилчид “Санамсаргүй олдворын үед ажиллах журам” мөн олдвор илэрсэн тохиолдолд авах арга хэмжээний тухай сургалтанд хамрагддаг.

БҮЛЭГ 6. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

6.1. Осол эрсдэлийг арилгах, бууруулах төлөвлөгөөний хүрээнд хийгдсэн ажлууд

Зорилго: Хөөтийн ордоос нүүрс олборлох, боловсруулах, тээвэрлэх төслийн бүхий л үйл ажиллагааны явцад байгаль орчин, хүний эрүүл мэндэд учирч болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, илэрсэн сөрөг нөлөөллийг арилгах, бууруулахад оршино.

Хүснэгт 13: Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний дагуу хийгдсэн ажлуудын гүйцэтгэл

№	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Арга хэмжээний цар хүрээ	Биелэлтийн шалгуур	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал
1	Осол эрдэлийн тухай нийт ажилчдад сургалт явуулах	Нийт ажилтан	Жилдээ	Гарч болзошгүй осол эрсдэлийн тухай сургалт, зааварчилгааг тогтмол орсон бөгөөд нийт ажилчдыг хувийн хамгаалах хэрэгслээр хангаж зориулалтын дагуу бүрэн хэрэглэж байгаа эсэхэд хяналт тавин ажилласан.	Үйл ажиллагааны зардлаас
2	Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн анхан болон давтан зааварчилгааг мөрдүүлж ажиллах, бүртгэл хөтлөх	Нийт ажилтан	Жилдээ	ХАБЭА болон Байгаль орчны ээлжит, ээлжит бус болон ажлын байрны анхан шатны зааварчилгааг улирал тутам болон шаардлагатай тохиолдол бүрт орж бүртгэл хөтөлсөн.	Үйл ажиллагааны зардлаас
3	Төслийн талбайд гал түймрээс сэргийлэх, эрсдэлийг бууруулах боломжтой арга хэмжээг авах. Эвдэрсэн, хугацаа нь дууссан галын хорыг цэнэглэх, солих	Уурхайн талбай дахь бүх барилга байгууламж	Жилдээ	Уурхайн хотхон дахь бүх амрах байрууд, гал тогоо, сургалтын өрөө зэрэг барилга байгууламжуудаас гадна уурхайд ажиллаж буй техникүүдэд галын хор байршуулж галын хорын үзлэг шалгалтыг сар бүр явуулж, шаардлага хангахгүй галын хорийг шинэчилэн	Үйл ажиллагааны зардлаас

				байршуулсан. Мөн нийт ажилчдад галын хор ажиллуулах заавар болон ослын үед авах арга хэмжээний сургалтыг тогтмол орсон.	
4	Хөдөлмөр хамгаалал, байгаль орчны чиглэлээр үзлэг шалгалт хийж уурхайн удирдлагад тайлагнаж, үл тохирлыг арилгаж ажиллах	Уурхайн хэмжээнд	Жилдээ	Байгаль орчин болон хөдөлмөр хамгааллын чиглэлээр хяналт мониторинг явуулж үр дүнг удирдлагуудад танилцуулсан.	Үйл ажиллагааны зардлаас
5	Үерийн уснаас хамгаалсан шуудуу эвдэрсэн тохиолдолд засах	Уурхайн хэмжээнд	Жилдээ	Үерийн уснаас хамгаалсан шуудуу эвдрээгүй.	Үйл ажиллагааны зардлаас

6.1.1. Осол эрсдэлийн тухай нийт ажилчдад сургалт явуулах

Газар хөдлөлт, байгалийн гамшигт үзэгдэл, олныг хамарсан үйлдвэрлэлийн осол гарах үед ажилчид аюулгүй байршилд очих буюу цугларах цэгт цуглах, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх, аврах эрэн хайх бүлэгт ослын мэдээллийг үнэн зөв өгөх мөн өндөрт ажиллах, хүнд даацын техникүүдтэй ажиллах, галын үед хэрэгжүүлэх арга хэмжээ зэрэг гарч болзошгүй осол эрсдэлийн тухай сургалт, зааварчилгааг тогтмол орсон бөгөөд нийт ажилчдыг хувийн хамгаалах хэрэгслээр хангаж зориулалтын дагуу бүрэн хэрэглэж байгаа эсэхэд хяналт тавин ажилласан.



Зураг 23: Нийт ажилчдад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт орж байна



Зураг 24: Ажилчид галын ослын үед авах арга хэмжээний зааварчилгаанд хамрагдаж буй нь


6.1.2. Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн анхан болон давтан зааварчилгааг мөрдүүлж ажиллах

Манай байгууллага нь MNS4969:2000 стандарт болон Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/370 тоот тушаалаар компанийн нийт ажилчдад ХАБЭА-н сургалт, зааварчилгааг байнга орж ажилладаг. Үүнд:


Хүснэгт 14: Хөдөлмөр хамгааллын чиглэлээр ордог сургалт, түүний давтамж

№	ХАБЭА зааварчилгаа	Давтамж
1	Урьдчилсан зааварчилгаа	Шинэ ажилчдад
2	Ажлын байран дахь анхан шатны зааварчилгаа	Шинэ болон ажлын байрны нөхцөл өөрчлөгдсөн ажилчдад
3	Давтан зааварчилгаа	Ээлжит
4		Ээлжит бус
5		Өдөр тутмын
6	Шинэ ажилтны сургалт	Шинэ ажилчдад
7	Нийт ажилтны сургалт	Жилд 2 удаа
8	Ажил олгогчийн сургалт	Жилд 1 удаа
9	Эрсдэлтэй ажлын байрны сургалт	2 жилд 1 удаа
10	Тусгай сургалт	Тухай бүрт

Дээрх байдлаар Байгаль орчин болон Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зааварчилгааг орж бүртгэл хөтөлдөг.



Зураг 25: Уурхайн нэг ээлжийн ажилчдад осол эрсдэлийн тухай сургалт орж буй нь



Чарт 4: Сургалтанд хамрагдсан ажилчдын тоо

Тайлант онд нийт 21 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 300 ажилтан хамрагдсан байна.

6.1.3. Төслийн талбайд гал түймрээс сэргийлэх, эрсдэлийг бууруулах боломжтой арга хэмжээг авах

Уурхайн амрах байрууд, гал тогоо, сургалтын өрөө, автопүү, 35кV дэд станц зэрэг бүх барилга байгууламжуудаас гадна уурхайд ажиллаж буй техник болгонд 2, 6, 8 кг-ын галын хоруудыг тус тус байршуулсан. Мөн галын хорын үзлэг шалгалтыг сар тутам явуулж, шаардлага хангахгүй галын хорийг шинэчилсэн бөгөөд нийт ажилчдад галын хор ажиллуулах заавар болон ослын үед авах арга хэмжээний сургалтыг тогтмол орсон.



Зураг 26: Сургалтын өрөөний галын аюулгүй ажиллагааны самбар болон уурхайн хотхон дахь галын сарай



Зураг 27: Уурхайн техникүүд болон амрах байруудад гал хор байршуулсан байдал

6.1.4. Хөдөлмөр хамгаалал, байгаль орчны чиглэлээр хяналт мониторинг хийх

Байгаль орчин болон хөдөлмөр хамгааллын чиглэлээр хяналт мониторинг явуулах уурхайн дотоод хуваарийн дагуу үзлэг хийж, илэрсэн зөрчил, дутагдлыг удирдлагад тайлагнан зөрчлыг арилгах, бууруулах арга хэмжээг авч ажилласан.



Зураг 28: Хөдөлмөрийн аюулгүй байдал болон байгаль орчны чиглэлээр хийгддэг үзлэг мониторинг

6.1.5. Үерийн уснаас хамгаалсан шуудуу эвдэрсэн тохиолдолд засах

Үерийн усны далан шуудуу хэвийн, эвдрэлгүй байна.



Зураг 29: Үерийн усны, далан шуудуу

БҮЛЭГ 7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

7.1. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний дагуу хийгдсэн ажлууд

Компанийн хэмжээнд мөрдөгдөж байгаа “Үйлдвэр уурхайн хог хаягдлын менежментийн төлөвлөгөө”-г хэрэгжүүлэн уурхайн хог хаягдал ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах журмын дагуу ажилласан.

Хүснэгт 15: Хог хаягдлаас үүсч болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээний гүйцэтгэл


№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Биелэлтийн шалгуур	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал
1	Хог хаягдлын цэгт ариутгал халдваргүйжүүлэлт хийх	Хог хаягдлын цэгт	Жилд нэг удаа	Хог хаягдлын цэгт тогтмол ариутгал, халдваргүйжүүлэлт хийсэн.	Үйл ажиллагааны зардлаас
2	Уурхай орчмын хог хаягдлын цэвэрлэгээ хийх хуваарь гарган уурхайн даргаар батлуулж, хуваарийн дагуу цэвэрлэгээ хийж бүртгэл хөтлөх	Уурхайн хэмжээнд	Тухай бүрт	Уурхай орчмын хог хаягдлын цэвэрлэгээний хуваарь гарган уурхайн удирдлагаар батлуулж, заасан хугацааны дагуу нийт ажилчдыг хамруулан их цэвэрлэгээ	Үйл ажиллагааны зардлаас

				хийсэн.	
3	Дахивар хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах боложийг илүү сайжруулан, хатуу хучилттай хогийн цэгийг шинэчилэн байгуулж хөрсний бохирдлоос сэргийлнэ	Хог хаягдлын цэгт	Жилдээ	Уурхайн хог ангилан ялгаж түр хадгалах цэгийг шинээр төлөвлөн байгуулсан.	Үйл ажиллагааны зардлаас
4	Ангилан ялгасан дахиварыг холбогдох байгууллагад хүргүүлэх	Уурхайн хэмжээнд	Жилдээ	Уурхайн хэмжээнд дахиварыг цуглуулан Эко говь ХХК-д хүргүүлсэн.	Үйл ажиллагааны зардлаас
5	Аюултай хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрт өгөх	Уурхайн хэмжээнд	Жилдээ	Аюултай хог хаягдыг төвлөрүүлэн Дорноговь аймгийн Даланжаргалан суманд байрлах МАК Цемент шохойн үйлдвэр рүү ачуулдаг. Тэндээс нэгдсэн байдлаар “Алтан оршихуй” ХХК-д хүргэддэг.	Үйл ажиллагааны зардлаас

7.1.1. Хог хаягдлын цэгт ариутгал халдваргүйжүүлэлт хийх

Манай байгууллагын “Сан хими” ХХК-тай хамтран ажиллах гэрээны дагуу тус байгууллага Хөөтийн уурхайн ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг 2022.07 сард гүйцэтгэсэн. Сан хими ХХК нь Клорсепт 17, жавелион, ДП-2Т нэрийн бодисуудын 0.03-0.06%-ийн уусмал ашиглан ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлын хийдэг.

Мөн бид дотооддоо мананцар ариутгагч ашиглан уурхайн бүх барилга байгууламж болон хогийн цэгт ариутгал хийдэг болно.





Зураг 30: Хогийн цэг болон нийт барилга байгууламжид ариутгал, халдваргүйжүүлэлт хийгдэж байна

7.1.2. Уурхай орчмын хог хаягдлын цэвэрлэгээ хийх хуваарь гарган уурхайн даргаар батлуулж, хуваарийн дагуу цэвэрлэгээ хийж бүртгэл хөтлөх

Уурхай орчмын хог хаягдлыг улиралд хоёр удаа цэвэрлэхээр хуваарь гарган уурхайн удирдлагаар батлуулж, заасан хугацааны дагуу нийт ажилчдыг хамруулан уурхайн тусгай зөвшөөрлийн талбайнууд болон болон гадаад технологийн зам дагуух 9 км зайд нийт 10 удаагийн их цэвэрлэгээ хийсэн байна.





Зураг 31: Хог цэвэрлэгээний хуваарийн дагуу нийт ажилчдыг хамруулан ээлжит цэвэрлэгээг хийж байна

7.1.3. Дахивар хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах боложийг илүү сайжруулан, хатуу хучилттай хогийн цэгийг шинэчилэн байгуулж хөрсний бохирдлоос сэргийлнэ

Менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу хөрсний бохирдлоос сэргийлэх, уурхайн хэмжээнд хог хаягдлын хэмжээг бууруулах, дахин ашиглах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор уурхайн хогийн цэгийг шинэчилэн хог хаягдлыг ангилан ялгаж түр хадгалах цэгийг байгуулсан. Бид энэхүү байгууламжид хаягдлыг энгийн, дахивар, бусад гэсэн 3 хэсэгт хуваан түр хадгалж байна. Энгийн хог хаягдалд устгах, ландфилл хийх хог хаягдлууд орох бол бусад хэсэгт уурхайн барилга байгууламжууд, засвар үйлчилгээний төвөөс гарах шатаах хог хаягдлууд орно. Бид энгийн хог хаягдлыг Баянжаргалан сумтай хийсэн хог хаягдлын гэрээний дагуу сумын хогийн цэгт төвлөрүүлэх бол дахивар хог хаягдлыг Дундговь аймагт байрлах дахивар авах аж ахуй нэгжид хүргүүлэхээр цуглуулж байна.



Зураг 32: Шинээр байгуулсан хог хаягдлыг ангилан ялгаж түр хадгалах цэг

Мөн уурхайн нийт ажилчдад хог хаягдлын менежмент, хог хаягдлыг ангилан ялгах 2 удаагийн сургалт орсон. Уурхайд үүсэх хог хаягдалын бүртгэлийг хөтөлж сар бүрийн мэдээнд тусгадаг.



Зураг 33: Дахиварыг эх үүсвэр дээр нь ангилж буй нь

7.1.4. Дахин ашиглах боломжтой хог хаягдлыг мэргэжлийн байгууллагад өгөх

Хөөтийн уурхайд төвлөрсөн дахин ашиглагдах боломжтой хаягдлыг МАК Цемент-шохойн үйлдвэрт хүргүүлж, тэндээс Дорноговь аймагт байрлах “Эко Говь” хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрт хандивласан. Тус байгууллага нь хуванцарыг дахин ашиглан ахуйн хэрэглээний сандал ширээ зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг.



Зураг 34: Цуглуулсан дахивар хуванцарыг боловсруулах үйлдвэрт хүргүүлж буй нь

7.1.5. Аюултай хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрт өгөх

Аюултай хог хаягдыг төвлөрүүлэн Дорноговь аймгийн Даланжаргалан суманд байрлах МАК Цемент-шохойн үйлдвэр рүү ачуулдаг бөгөөд Цемент шохойн үйлдвэр нь гэрээний дагуу нэгдсэн байдлаар хаягдал тос хүлээн авах байгууллагад нийлүүлдэг.



Зураг 35: Хаягдал тосыг зохих байдлаар түр хадгалж мэргэжлийн байгууллагад хүргүүлдэг

БҮЛЭГ 8. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Зорилго: Хяналт шинжилгээний хөтөлбөрийг БОННУ-нд зөвлөмж болгосны дагуу тодорхойлсон хяналтын цэгүүд дээр, хуваарийн дагуу явуулж уурхайн үйл ажиллагаанаас үүсэн гарах нөлөөллийг хянах, хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд байлгахад оршино.

8.1. Усны чанарын хяналт шинжилгээ

Уурхайн усны хяналтыг Хөөтийн булаг, ундны ус, шүүрлийн ус гэсэн 3 цэгээс “Хан лаб”, Дундговь аймгийн УЦУОШТөвийн байгаль орчны шинжилгээний лабораториор химийн шинжилгээг гүйцэтгүүлсэн.

Хүснэгт 16: “Хан лаб” болон Дундговь аймгийн УЦУОШТ-өөр шинжлүүлсэн усны хими шинжилгээний хариу

№	Тодорхойлсон үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 он					Ундны усны эрүүл ахуйн шаардлага MNS 0900:2018	Усан орчны чанарын үзүүлэлт MNS 4586:98
			Ундны ус			Шүүрлийн ус	Хөөтийн булаг		
			07.19	08.05	06.20	08.05	08.05		
1	Усны орчин	pH	7.80	8.05	7.95	7.42	7.88	6.5-8.5	6.5-8.5
2	Цахилгаан дамжуулах чанар	мСм	-	-	-	7600	2890	<1.0	-
3	Ерөнхий хатуулаг	мг-экв/л	6.75	11.31	5.98	58.5	18.33	<7.0	-
4	Кальци	мг/л	68.25	136.9	60.15	312.6	273.5	<100.0	
5	Магни	мг/л	40.59	54.5	36.18	521.7	56.9	<30.0	-
6	Карбонат	мг/л	1.50	-	<1.5			-	-
7	Хлорид	мг/л	54.45	85.1	56.15	726.7	163.1	<350.0	<300.0
8	Гидрокарбонат	мг/л	414.9	427.1	335.6	1403.4	1159.3	-	-
9	Нитрит	мг/л	<0.05	0.020	<0.05	0.510	0.020	<1.0	<0.02
10	Нитрат	мг/л	0.79	0.32	0.68	0.32	0.50	<50.0	<0.9
11	Төмөр	мг/л	0.07	0.09		0.24	0.19	<0.3	-
12	Сульфат	мг/л	122.0	230.5	118.8	3114.8	461.1	<500.0	<100.0
13	Хуурай үлдэгдэл	мг/л	618	-	-	14.0	-	<1000.0	-
14	Натри	мг/л	94.13	72.3	83.47	1246.3	371.8	<200.0	-
15	Кали	мг/л	2.13		1.72			-	-
16	Аммони	мг/л	<0.10	0.06	<0.10	13.77	0.10	<1.5	<0.5
17	Цахиурын хүчил	мг/л	16.38	-	15.08	-	-	-	-
18	Исэлдэх чадвар	мгО ₂ /л	3.36	4.2	1.28	79.0	9.5	-	-
19	Фосфат	мг/л	<0.05	0.033	<0.05	0.110	0.08	-	3.5
20	Фтор	мг/л	2.43	0.23	2.08	3.9	2.03		0.7-1.5
21	Хүхэртуст өрөгч	мг/л	<0.10	-	<0.10	-	-	-	0.1
22	Чөлөөт хлорид	мг/л	<0.10	-	<0.10	-	-	-	0.2-0.3

23	Булингар	NT U	<10.0	-	<10.0	-	-	-	1.5
24	Мөнгө	мг/л	<0.01	-	<0.01	-	-	-	0.1
25	Хөнгөнцагаан	мг/л	<0.025	-	<0.025	-	-	-	0.50
26	Мышьяк	мг/л	<0.01	-	<0.01	-	-	-	0.01
27	Бор	мг/л	0.26	-	0.23	-	-	-	2.40
28	Бари	мг/л	0.02	-	0.02	-	-	-	0.70
29	Берелли	мг/л	<0.001	-	<0.001	-	-	-	0.0002
30	Кадми	мг/л	<0.005	-	<0.005	-	-	-	0.003
31	Кобальт	мг/л	<0.001	-	<0.001	-	-	-	-
32	Хром	мг/л	<0.005	-	<0.005	-	-	-	0.05
33	Зэс	мг/л	0.02	-	<0.02	-	-	-	2.0
34	Марганец	мг/л	<0.01	-	<0.01	-	-	-	0.1
35	Молибден	мг/л	0.007	-	<0.05	-	-	-	0.07
36	Никель	мг/л	<0.005	-	<0.05	-	-	-	0.02
37	Хартугалга	мг/л	<0.01	-	<0.01	-	-	-	0.01
38	Сурьма	мг/л	<0.01	-	<0.01	-	-	-	0.02
39	Селен	мг/л	<0.05	-	0.018	-	-	-	0.04
40	Стронци	мг/л	1.56	-	1.40	-	-	-	2.00
41	Уран	мг/л	<0.50	-	<0.50	-	-	-	0.03
42	Цайр	мг/л	0.01	-	<0.01	-	-	-	5.0
43	Цианид	мг/л	<0.002	-	<0.002	-	-	-	0.01
44	Мөнгөн ус	мг/л	<0.001	-	<0.001	-	-	-	0.001

8.2. Хөрсний хяналт шинжилгээ

Уурхайн хөрсний хяналтын (технологийн зам, карьер, хогийн цэг, ажилчдын хотхон, шимт хөрсний овоолго) цэгүүдээс дээж авч, “ХАНЛАБ” ХХК, Дундговь аймгийн УЦУОШТөвийн Байгаль орчны шинжилгээний лаборатороор хүнд металл, ерөнхий химийн үзүүлэлтийг шинжлүүлсэн.

Хөрсөн дэх хүнд металлын агууламжийн шинжилгээг БОМТ-д тусгагдсаны дагуу дараах байршлуудад хийж гүйцэтгэсэн. Хүнд металлын шинжилгээг итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлсэн бөгөөд шинжилгээний үр дүнг стандарттай харьцуулсныг доорх хүснэгтэд үзүүлэв.

2022.06.20					
Дээж авсан байршил	Элемент, %				
	Al*	Ca	Mg	K	Fe _{нийт}
Уурхайн хотхон орчим	4.5	0.68	0.28	2.74	1.63
Уурхайн карьер	4.40	0.32	0.20	2.47	1.50
Шимт хөрсний овоолго	4.99	0.61	0.41	2.67	2.38
Уурхайн хөрсний овоолго	4.66	1.00	0.50	2.42	2.97
Технологийн зам	5.00	0.89	0.39	1.71	4.07
2022.06.20					
Дээж авсан байршил	Элемент, мг/кг				
	As	Ba*	Be	Bi	Cd
Уурхайн хотхон орчим	12.53	653.4	<5.0	<10	<1.0
Уурхайн карьер	5.61	573.6	<5.0	<10	<1.0
Шимт хөрсний овоолго	15.76	680.0	<5.0	<10	<1.0
Уурхайн хөрсний овоолго	16.46	538.7	<5.0	<10	<1.0
Технологийн зам	68.56	510.4	<5.0	<10	1.50
MNS5850:2019	20.00	-	-	-	3.00
2022.06.20					
Дээж авсан байршил	Элемент, мг/кг				
	Co	Cr	Cu	La	Li
Уурхайн хотхон орчим	8.83	24.01	6.92	20.17	16.59
Уурхайн карьер	10.13	18.99	6.69	16.94	17.66
Шимт хөрсний овоолго	12.21	32.61	11.86	14.99	19.27
Уурхайн хөрсний овоолго	16.42	52.01	12.25	22.87	24.56
Технологийн зам	19.23	25.91	29.39	35.50	31.80
MNS5850:2019	50.00	150.0	100.0	-	-
2022.06.20					
Дээж авсан байршил	Элемент, мг/кг				
	Mn	Mo	Ni	P	Pb
Уурхайн хотхон орчим	312.0	<5.0	8.56	668.7	14.21
Уурхайн карьер	398.5	<5.0	9.98	527.7	17.66
Шимт хөрсний овоолго	476.0	<5.0	14.92	746.6	20.01
Уурхайн хөрсний овоолго	561.0	<5.0	15.38	930.8	26.63
Технологийн зам	1347	14.27	20.65	3813	45.95
MNS5850:2019	-	5.0	150.0	-	100.0
2022.06.20					
Дээж авсан байршил	Элемент, мг/кг				
	Sb	Se	Sr*	Ti	V
Уурхайн хотхон орчим	<10.0	<5.0	225.0	2542	44.93
Уурхайн карьер	<10.0	<5.0	159.5	1825	36.67
Шимт хөрсний овоолго	<10.0	<5.0	219.1	2521	55.13

Уурхайн хөрсний овоолго	<10.0	<5.0	217.5	3575	74.32
Технологийн зам	<10.0	<5.0	321.7	2441	76.99
MNS5850:2019		10.00	800.0	-	150.0
2022.06.20					
Дээж авсан байршил	Элемент, мг/кг				
	Ү	Zn	Zr*	-	-
Уурхайн хотхон орчим	10.57	50.61	74.95	-	-
Уурхайн карьер	10.34	62.35	71.38	-	-
Шимт хөрсний овоолго	10.42	83.05	79.16	-	-
Уурхайн хөрсний овоолго	14.64	104.0	112.4	-	-
Технологийн зам	23.87	175.1	143.7	-	-
MNS5850:2019	-	300.0	-	-	-

Хяналтын цэгүүдээс авсан хөрсний дээжүүдээс шинжилсэн дараах 6 төрлийн үзүүлэлт “Хөрс бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” Монгол улсын стандарт MNS 5850:2019-т зааснаас хэтрээгүй байна.

Хүснэгт 18: Дундговь аймгийн УЦУОШТ-өөр гүйцэтгүүлсэн хөрсний агрохимийн үзүүлэлт

Дээж авсан байршил	Хөрсний чанарын үзүүлэлтүүд					
	pH	Ялзмаг %	Нитратын азот /NO3/ мг/кг	Амиакийн азот /NH4/ мг/кг	Сульфат /SO4/ мг/кг	Фосфор /P2O5/ мг/кг
Шимт хөрсний овоолго 45°41'14.3" 107°41'14.3"	9.1	1.5	2.52	7.42	1392.9	2.62
Технологийн зам 45°41'33.3" 107°41'01.8"	6.52	0.77	1.25	35.6	1953.6	0.58
Уурхайн карьер 45°41'21.8" 107°40'48.6"	7.86	0.85	24.6	83.65	2853.4	3.10
Хогийн цэг 45°42'07.2" 107°40'02.5"	8.85	1.25	4.44	4.52	234.6	2.0
Ажилчдын хотхон 45°42'08.2" 107°40'03.8"	9.1	1.13	2.47	3.25	202.6	0.8

8.3. Агаарын хяналт шинжилгээ

Агаарын чанарын мониторингийг 5-10-р саруудад дотооддоо хийсэн бөгөөд гадна 8-р сард мэргэжлийн байгууллагаар буюу Дундговь аймгийн ус цаг уур, орчны шинжилгээний төвийн байгаль орчны шинжилгээний лабораториор нийт тоос, нарийн ширхэгт тоосонцор РМ (2.5), РМ (10), хүхэрлэг хий SO₂, азотын давхар исэл NO₂ зэрэг элементүүдийг шинжлүүлсэн. Шинжилгээний үр дүнгээс харахад Монгол улсад мөрдөгдөж буй агаарын чанарын стандарт MNS 4585:2016 стандартад заасан үзүүлэлтээс хэтрээгүй байна.

Хүснэгт 19: Дундговь аймгийн УЦУОШТөвөөр гүйцэтгүүлсэн агаарын чанарын шинжилгээний хариу


№	Сорьц авсан цэг	Хүхэрлэг хий (SO ₂) мг/м ³	Азотын давхар исэл (NO ₂) мг/м ³	20 минут дахь нийт тоос мг/м ³
1	Технологийн зам 45°41'33.3" 107°41'01.8"	0.011	0.018	0.008
2	Уурхайн карьер 45°41'21.8" 107°40'48.6"	0.014	0.011	0.007
3	Ажилчдын хотхон орчим 45°42'08.2" 107°40'03.8"	0.012	0.021	0.009
4	Уурхайн нөлөөллийн өрх орчим 45°42'20.6" 107°39'29.9"	0.013	0.013	0.008
Агаарын чанарын стандарт MNS 4585:2016		0.450	0.20	0.50

Бид дотооддоо нарийн ширхэгт тоосонцор буюу РМ (10), РМ (2.5) болон агаарын найрлагыг уурхайн карьер, технологийн зам, ажилчдын хотхон, нөлөөллийн бүс дахь өрх орчим гэсэн мониторингийн цэгүүдэд PCE-RCM 10, Multi-gas Detector агаарын чанар хэмждэг багажууд ашиглан V-X саруудад хийж гүйцэтгэсэн.



Граф 1: Нарийн ширхэгт тоосонцор PM (2.5), PM (10)-ийн хэмжилтийн үр дүн

Мониторингийн үзүүлэлтээс дүгнэхэд уурхайн ажилчдын хотхон, нөлөөллийн бүс дахь айл орчмын нарийн ширхэгт тоосонцорын хэмжээ MNS 4585:2016 стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй. Харин уурхайн карьер, технологийн зам дагуух нарийн ширхэгт тоосонцорын хэмжээ VII, VIII саруудад стандартад заасан хэмжээнээс хэтэрсэн байгааг харж байна. Энэ нь тухайн саруудад байгалийн давагдашгүй хүчин зүйл, салхи шуургатай өдрүүд ихээр үргэлжилсэнээс гадна уурхайн зам усалгааны машин эвдэрсэн тул зам усалгаа хийгдээгүйтэй холбоотой гэж үзэж байна.



Зураг 36: Агаарын чанар, найрлагын хэмжилт хийж байна

8.4. Амьтны аймгийн хяналт шинжилгээ

Уурхайн ажилчдад ордог Байгаль орчны багц сургалтын агуулгад амьтны үзэгдэлийг “Амьтны үзэгдэл бүртгэх хуудас”-т тэмдэглэх, мэдээлэх, ан амьтныг барьж тэжээхгүй байх зэрэг тусгагдсан байдаг. Мөн жилдээ 1 удаа төслийн талбай, ойролцоох орчмын амьтдын судалгаа, бүртгэлийг хөтөлж зурган хэлбэрээр баримтжуулдаг. Судалгаагаар амьтдын төрөл зүйлээр ангилж үзвэл элбэг тааралдах жижиг хөхтөн амьтдаас хээрийн бор хулгана, туулай, зараа. Мөлхөгч хэвлээр явагчдаас хонин гүрвэл. Том хөхтөн амьтдаас цагаан зээр. Жигүүртнээс хэрээ элбэг тааралдана.





Зураг 37: Уурхайн хотхоны талбайд элбэг үзэгдэх туулай, зараа ба Аргийн хад дахь аргалын үзэгдэл

8.5. Ургамлын судалгаа

Уурхайн тусгай зөвшөөрлийн талбайд VII сард раменскийн тор ашиглан ургамлан нөмрөгийн судалгааг мониторингийн 2 цэгт хийж гүйцэтгэсэн. Ургамлан бүрхэвчийн судалгаагаар тухайн цэгүүд дахь ургамлын зүйлийн бүрдэл, бодгалийн тоо, газрын дээрх ургамлын өндөр болон бүрхэцийг тодорхойлсон. 1 м² дахь ургамлан зүйлийн тоо 5-6 төрөл. Тэдгээр нь таана, мангир, хялгана зэрэг болно


Хүснэгт 20: Ургамлан нөмрөгийн судалгааны үр дүн

№	Мониторингийн цэгийн байршил	Ургамлын зүйл		Бодгалийн тоо	Бодгалийн өндөр	Вегатацын хугацаа	Амьдралын хэлбэр	Наслалт	Ургамлын бүрхэц	Зүйлийн тоо
		Латин	Монгол							
1	45.695883; 107.670672	Anabasis brevifolia	Түжгэр баглуур	3	9		Өвслөг ургамал	Олон наст	48%	4
2		Allium polyrhizum	Таана	8	23	VI-IX	Өвслөг ургамал	Олон наст		
3		Allium senescens	Мангир	2	16		Өвслөг ургамал	Олон наст		
4		Artemisia frigida	Шарилж	4	6	VI-IX	Сөөгөнцөр ургамал	Олон наст		
5	45.691614; 107.681056	Stipa glareosa	Сайрын хялгана	12	15		Өвслөг ургамал	Олон наст	53%	2
6		Allium polyrhizum	Таана	8	24		Өвслөг ургамал	Олон наст		


8.6. Дуу шуугианы хяналт шинжилгээ

Дуу шуугианыг дотооддоо PCE-EM 883 багажаар хяналтын цэгүүдэд сардаа нэг удаа хэмжсэн. Орчны дуу шуугиан “Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны MNS 4995 стандарт”-д заасан ажлын орчин дахь 24 цагийн дундаж 85 дБА хэмжээнээс хэтрээгүй.

Уурхайн карьер



Ажилчдын хотхон



Зураг 38: Дуу шуугианы хэмжээний үзүүлэлтүүд

*Тайлант онд уурхайн үйл ажиллагаанаас үүсэх дуу чимээний тухай ямар нэг гомдол ирээгүй болно.



Зураг 39: Орчны дуу чимээний хэмжилт хийж байна

БҮЛЭГ 9. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 21: Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу хийгдсэн ажлууд

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Биелэлтийн шалгуур	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал
1	Бүх ажилчдад байгаль орчны багц сургалтыг улирал тутамд орох.	4, 7, 9 саруудад	Уурхайн нийт ажилчдад 2 удаагийн Байгаль орчны багц сургалт орж бүртгэлжүүлсэн.	Үйл ажиллагааны зардлаас
2	Уурхайн газрын гэрээг хийж, төлбөр төлөх	3, 4, 5 саруудад	Уурхайн газрын гэрээг хийж, төлбөрийг төлсөн	44,725,456.0
3	Уурхайн ус ашиглах дүгнэлт гаргуулж зөвшөөрөл авах, гэрээ байгуулах	3, 4, 11 саруудад	Уурхайн ус ашиглах дүгнэлт гаргуулахаар IX.29-ны өдөр материалыг бүрдүүлж УГГХДТСГ-т хүргүүлсэн. Дүгнэлт гарахыг хүлээж байна.	100,000.0
4	Уурхайн хог хаягдлын гэрээг хийж, төлбөр төлөх	3, 4, 5 саруудад	Уурхайн хог хаягдлын гэрээ хийгдсэн.	-
5	Байгаль орчныг хамгаалах чиглэлээр орон нутаг болон иргэдтэй хамтран ажиллах санал санаачлагыг өөрийн нөхцөл боломжийн хүрээнд хэрэгжүүлэх	Тухай бүрт	Нөлөөллийн бүсийн иргэд, орон нутгаас ирсэн саналын дагуу малчны худгийг ашиглалтанд оруулах, цооногийг битүүмжлэх, зам засах зэрэг ажлууд хийгдсэн.	Үйл ажиллагааны зардлаас
6	Орон нутгийн иргэдтэй хамтран орчны хяналт шинжилгээ хийлгэнэ.	5, 6, 9 саруудад	Орчны хяналт шинжилгэний үр дүнг нөлөөллийн бүсийн иргэдэд танилцуулсан.	-
7	Техникийн тос, тосолгооны шингэн хаягдал тос хүлээлгэн өгөх, хүлээн авах гэрээ байгуулан ажиллах	3, 11 саруудад	Манай байгууллага нь тос тосолгооны материалыг “Алтан оршихуй” ХХК-д хүлээлгэн өгөх гэрээтэй.	Үйл ажиллагааны зардлаас
Нийт				44,825,456.0

9.1.1. Бүх ажилчдад байгаль орчны багц сургалтыг улирал тутамд орох

Уурхайн нийт ажилчдад 2 удаагийн Байгаль орчны багц сургалт орж бүртгэлжүүлсэн. Байгаль орчны багц сургалтанд дараах сэдвүүд багтсан:

- Байгууллагын байгаль орчны талаарх баримтлах бодлого
- Байгаль орчинтой холбоотой байгууллагын дотоод журмууд
- Хог хаягдлын менежмент, хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж хэвших
- Асгаралт мэдээлэх, арилгах бууруулах арга хэмжээ авах заавар

- Ургамлан нөмрөгийг хамгаалах, хурдны хязгаарыг мөрдөх, амьтны үзэгдэл мэдээлэх
- Санамсаргүй олдворын үед авах арга хэмжээ зэрэг болно.



Зураг 40: Уурхайн нэг ээлжийн ажилчдад Байгаль орчны сургалт орж байна

9.1.2. Уурхайн газрын гэрээг хийж, төлбөр төлөх

Уурхайн газрын гэрээг хийж, төлбөрийг төлсөн.

9.1.3. Уурхайн ус ашиглах дүгнэлт гаргуулж зөвшөөрөл авах, гэрээ байгуулах

Уурхайн ус ашиглах дүгнэлт авахаар IV сард материалуудыг бүрдүүлэн УГГХДТС Газрын захиргаанд хүргүүлсэн. Дүгнэлт гарахыг хүлээж байна.

9.1.4. Уурхайн хог хаягдлын гэрээг хийж, төлбөр төлөх

Уурхайн хог хаягдлын гэрээ хийгдсэн. Төлбөрийн оны эцсээр төлөхөөр төлөвлөгөөнд тусгасан байна.

9.1.5. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр орон нутаг болон иргэдтэй хамтран ажиллах санал санаачлагыг өөрийн нөхцөл боломжийн хүрээнд хэрэгжүүлэх

Иргэн Г. Мөнхдалайн хүсэлтээр 2021 онд гаргаж өгсөн цооногт энэ онд худгийн байр барьж, насос суурьлуулан ашиглалтанд оруулсан. Мөн иргэн Б. Ууганцэцэгийн хүсэлтээр ойролцоо байх 7 ширхэг цооногыг хааж битүүмжлээд байна. Нутгийн иргэдийн малын бэлчээрт тааралдах цооногуудыг оторын айлууд хэрэглэж суурин байрлах үзэгдэл ихэссэн тул иргэдийн хүсэлтын дагуу цооногуудыг хааж битүүмжлэх арга хэмжээ авсан.



Зураг 41: Иргэдийн хүсэлтийн дагуу цооногуудыг битүүлэх арга хэмжээ авч байна

9.1.6. Орон нутгийн иргэдтэй хамтран орчны хяналт шинжилгээ хийлгэнэ

Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хянах бууруулах, ажилчид болон ан амьтдны эрүүл мэндэд, аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдлээс хамгаалах, арилгах зорилгоор БОМТ-д тусгасны дагуу агаар, хөрс, ус болон орчны дуу чимээний хяналт шинжилгээг заасан хугацаанд гүйцэтгэж, шинжилгээний үр дүнг нөлөөллийн бүсийн өрхөд танилцуулсан.

9.1.7. Техникийн тос, тосолгооны шингэн хаягдал тос хүлээлгэн өгөх, хүлээн авах гэрээ байгуулан ажиллах

Манай байгууллага нь тос тосолгооны материалыг “Алтан оршихуй” ХХК-д хүлээлгэн өгөх гэрээтэй бөгөөд тус гэрээ нь VIII сарын 22-ны өдрөөр дуусгавар болсон тул дараагийн байгууллагатай гэрээ хийхээр судалж байна.

9.1.8. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд бэлтгэл ажлыг хангаж, уурхайн ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлнэ

Дээр дурьдсанчлан уурхайн хэмжээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлж нийт 1044 ширхэг мод бутыг тарьж арчилж байна. 2022 оны V сарын байдлаар уурхайн хэмжээнд 8 төрлийн нийт 1772 ширхэг мод бут ургаж байна.



Зураг 42: Хаврын тарилт хийгдэх үеийн болон дараах зургууд

Мөн тайлант онд “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Баянжаргалан сумын ЗДТГ-ын мод тарих ажлыг дэмжиж, ЗДТГ-ын хүсэлтээр тус суманд 100 ширхэг модны нүх ухсан байна.



Зураг 43: Уурхайн ажилчид Баянжаргалан суманд модны нүх ухаж байна

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЗАРЦУУЛСАН НИЙТ ЗАРДАЛ

№	Зардлын задаргаа /төгрөг/			Зардал /төгрөг/
1	Сөрөг нөлөөллийн бууруулах арга хэмжээний зардал	Агаар орчин хамгаалах чиглэлээр	10,398,000	15,046,900
		Усан орчинг хамгаалах чиглэлээр	148,900	
		Ургамлан бүрхэвч, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр	4,500,000	
2	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд			6,420,000
3	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хүрээнд			1,200,000
4	ОХШХ-ийг хэрэгжүүлэхэд	Усны шинжилгээ		1,937,410
		Хөрсний шинжилгээ		
		Агаарын шинжилгээ		
5	Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд хийсэн ажлуудад			44,825,456.0
Нийт				69,429,766

ДҮГНЭЛТ

“Монголын алт” (МАК) ХХК нь Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн дагуу Байгаль хамгааллын дүрэм журмыг чанд сахин, стандартуудыг мөрдлөг болгон ажиллаж байгаль орчинд учирч болох сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх ажлыг тогтмол гүйцэтгэдэг билээ.

Хөөтийн уурхайн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллийг бууруулах, дүйцүүлэн хамгаалах, орчны хяналт шинжилгээ болон удирдлага зохион байгуулалтын зэрэг 10 бүлэг чиглэлээр нийт 51 ажил хийгдэхээр тусгагдсанаас тайлант хугацааг хүртэл 49 ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн, 96%-ийн биелэлттэй байна. Олон нийтэд тайлагнах үйл ажиллагааны хүрээнд хийгдэхээр тусгасан 3 ажлыг заасан хугацааны дагуу гүйцэтгэж, биелэлтийг тайлагнахаар байна.

2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 12,267,000 төгрөг төлөвлөн тусгаж, тайлант оны X сарын байдлаар менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг гаргахад 69,429,766 төгрөг зарцуулсан байна.

ХАВСРАЛТ МАТЕРИАЛУУДЫН ЖАГСААЛТ

1. Аж ахуй нэгжийн гэрчилгээ
2. Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл, төлбөр төлсөн баримт
3. БОХ-3 маягт
4. Хог хаягдлын гэрээны хуулбар
5. Газрын гэрээ, газрын төлбөр төлсөн баримт
6. Агаарын шинжилгээний хариуны хуулбар
7. Хөрсний шинжилгээний хариуны хуулбар
8. Усны шинжилгээний хариуны хуулбар
9. Дүйцүүлэн хамгаалах ажил гүйцэтгэж, орон нутагт хүлээлгэн өгсөн акт
10. Баянжаргалан сумын ЗДТГазарт 450 боодол өвс хүлээлгэн өгсөн акт
11. Хаягдал тос хүлээлгэн өгөх гэрээ, хаягдал тос нийлүүлсэн акт
12. Шүүрлийн усны насост тоолуур суурьлуулсан акт

УБ-2

Монгол Улсын Засгийн газрын
2004 оны 20 дугаар тогтоолоор батлав.



МОНГОЛ УЛС УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000014445

2006.02.17

/Бүртгэсэн он, сар, өдөр/

9011071054

/Улсын бүртгэлийн дугаар/

2095025

/Регистрийн дугаар/

Монголын алт МАК

Хязгаарлагдмал хариуцлагатай компани

/Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр/

Дүрэм

/Үүсгэн байгуулах баримт бичиг/

Шийдвэр

/шийдвэрийн нэр/

01

/дугаар/

1996.08.30

он, сар, өдөр

132000
/код/

Алт болон эрдэс баялаг, бусад төрлийн ашигт малтмалыг олборлон боловсруулах, хайгуул хийх
/Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл/

511000

Гадаад худалдаа

751300

Аялал жуулчлал

011200

Газар тариалан, хүнсний ногоо тариалах

749200

Гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагаа

/код/

/Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл/

Хугацаагүй

хугацаа

1

/гшиүүдийн тоо/

31,747,976.2

/өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр/

Баянзүрх, 18-р хороо, 13-р хороолол, Өөрийн байранд --, утас1:455785, утас2:450876, факс:458075

/хуулийн этгээдийн албан ёсны хаяг/

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн
этгээдийн бүртгэлийн газар

УХАА /Бүртгэсэн байгууллагын нэр/

Гэрчилгээг дахин олгосон: 2011 он 03 сар 11 өдөр



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗАР

АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар 12199А

Ашигт малтмалын тухай Монгол улсын хуулийн 26 дугаар зүйлийг үндэслэн

Дундговь аймаг /хот/-ийн

Баянжаргалан сум /дүүрэг/-ын

Уст нэртэй газарт орших

1444 гектар талбай бүхий уурхайн талбайд хуульд

заасан нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал ашиглахыг

зөвшөөрч улсын бүртгэлийн 9011071054 тоот гэрчилгээтэй

„Монголын алт МАК„ ҮБҮЖ -д

энэхүү тусгай зөвшөөрлийг 30 жилийн

хугацаагаар олгов.

Тусгай зөвшөөрөл хавсралтгүй бол хүчингүй.

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ХЭРЭГ

ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Л. БОЛД

2007 оны 01 сарын 29 өдөр

Улаанбаатар хот



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ

MV-012199

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Хөдөлгөөний код	Хөдөлгөөний тайлбар	Гарын үсэг, огноо, тамга
000-CI	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Ашигт малтмалын газрын даргын 2010 оны 127 тоот тушаалын дагуу ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайн солбицлыг WGS-84 тогтолцоонд албан ёсоор хөрвүүлж талбайн хэмжээг дахин тооцсон.	
005-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 5 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2010.11.09 – 2011.11.09 хүртэл	2010-11-09
007-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 6 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2011.11.09 – 2012.11.09 хүртэл	2011-11-09
007-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 7 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2012.11.09 – 2013.11.09 хүртэл	2012-11-06
008-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 8 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2013.11.09 – 2014.11.09 хүртэл	2013-11-06
009-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 9 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2014.11.09 – 2015.11.09 хүртэл	2014-11-04
010-PL	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийг УХН11635 тоот улсын бүртгэлийн дугаартай Монгол улсын хөгжлийн Банк Банк-д барьцаалахКадастрын хэлтсийн даргын 2015.01.30-ний 54 тоот шийдвэр	



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ

MV-012199

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Огноо, гарын үсэг, тэмдэг
011-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 10 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2015.11.09 – 2016.11.09 хүртэл	2015-11-04
012-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 11 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2016.11.09 – 2017.11.09 хүртэл	2016-11-14
013-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 12 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2017.11.09 – 2018.11.09 хүртэл	2017-11-06
014-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 13 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2018.11.09 – 2019.11.09 хүртэл	2018-11-02
015-PE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: 9016001019 тоот улсын бүртгэлийн дугаартай Монгол улсын хөгжлийн банкны барьцаанаас чөлөөлөхКадастрын хэлтсийн даргын 2019.10.17-ны 518 тоот шийдвэр	2019-10-17
016-PL	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийг 9016001019 тоот улсын бүртгэлийн дугаартай Монгол улсын хөгжлийн банк Банканд барьцаалахКадастрын хэлтсийн даргын 2019.10.31-ний 536 тоот шийдвэр	2019-10-31
017-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 14 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2019.11.09 – 2020.11.09 хүртэл	2019-11-06




ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 2 ДУГААР ХАВСРАЛТ

MV-012199

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Хөдөлгөөний код	Хөдөлгөөний тайлбар	Хүчин төгөлдөр талбайн хэмжээ /га/	Хасагдах талбайн хэмжээ /га/	Тусгай зөвшөөрлийн талбайн солбицлууд, гарын үсэг, огноо, тамга
000-CI	<ul style="list-style-type: none">Ашигт малтмалын газрын даргын 2010 оны 127 тоот тушаалын дагуу ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайн солбицлыг WGS-84 тогтолцоонд албан ёсоор хөрвүүлж талбайн хэмжээг дахин тооцсон.	1443.73 Га	0 Га	1 107° 44' 1.53" 45° 40' 1.6" 2 107° 40' 1.52" 45° 40' 1.6" 3 107° 40' 1.54" 45° 41' 31.61" 4 107° 44' 1.53" 45° 41' 31.61"



Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны А/134 дүгээр тушаалаар зөвшөөрснөөр, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 09 сарын 19-ны өдрийн А/527 дугаар тушаалаар батлав.

УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УЛМААС ЭВДЭРСЭН ГАЗРЫН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН
2022 ОНЫ ЖИЛИЙН МЭДЭЭ

1. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ХАЯГИЙН ХЭСЭГ

Регистрийн дугаар	2	0	9	5	0	2	5
Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Монголын Алт МАК ХХК						
Байршил	Нэр			Код			
Аймаг, нийслэл	ДУНДГОВЬ			4	8		
Сум, дүүрэг	БАЯНЖАРГАЛАН			0	7		

2. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Тусгай зөвшөөрлийн дугаар	М	У	0	1	2	1	9	9
Тусгай зөвшөөрлийн талбай, га	1444							
Ашиглалт эхэлсэн он, сар, өдөр	2	0	1	3				
Ашигт малтмалын төрөл	Чулуун нүүрс							
Ашиглалтын төрөл	Ил уурхай							

3. УУЛ УУРХАЙН АШИГЛАЛТ

Үзүүлэлт	МД	Хэмжих нэгж	Нийт	Тайланд онд (ашиглалт хийсэн)
А	Б	В	1	2
Олборлолтод өртсөн нийт талбай	1	-		
Ашигласан талбай	2	га	23.2	2.61
	3	мян.м ³	2,266	222,961
Хаягдал чулуулгийн овоолго	4	га		
	5	мян.м ³		
Хөрсний овоолго	6	га	11,7	0.6
	7	мян.м ³	2,119	143
Уул уурхайн дагалдах дэд бүтцийн нөлөөнд эвдэрсэн газар	8	га	1.6	0.6
Бусад	9	га		

4. УУЛ УУРХАЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ

Үзүүлэлт	МД	Хэмжих нэгж	Нийт	Техникийн	Биологийн
А	Б	В	1	2	3
Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээнд заасан нөхөн сэргээлт хийх нийт талбайн хэмжээ	10	га	301,84		
	11	мян.м ³			
Тайланд онд нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн талбай	12	га	2		
	13	мян.м ³	-		
Нөхөн сэргээлт нийт хийсэн талбай, мөр14≥ мөр16, мөр15≥ мөр17	14	га	-		
	15	мян.м ³	-		
Тайланд онд нөхөн сэргээлт хийсэн талбай	16	га	2		2
	17	мян.м ³	-		
Нөхөн сэргээлт хийхэд зарцуулсан нийт зардал, мөр18≥ мөр19	18	мян.төг	1,200,000		
	19	мян.төг	1,200,000		1,200,000
Байршуулсан нөхөн сэргээлтийн баталгааны нийт мөнгөн хөрөнгө, мөр20≥ мөр21	20	мян.төг	11,418,500		
	21	мян.төг	6,133,500		
Байгаль хамгаалахад зарцуулсан нийт зардал, мөр22≥ мөр23	22	мян.төг	316,581,266		
	23	мян.төг	68,429,766		

Уурхайн дарга..... *А. Эрдэнэбаатар* /А. Эрдэнэбаатар/

Уулын инженер..... *Ц. Туяахүү* /Ц. Туяахүү/

Байгаль орчны мэргэжилтэн..... *А. Халиунаа* /А. Халиунаа/

БАТЛАВ.
“МОНГОЛЫН АЛТ” (МАК) ХХК-ИЙН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н. ЦЭЛМҮҮН



БАТЛАВ.
ДУНДГОВЬ АЙМГИЙН
БАЯНЖАРГАЛАН СУМЫН
ЗАСАГ ДАРГА Г. ЦЭВЭЛМАА



ХОГ ХАЯГДЛЫН ГЭРЭЭ

2022 он 02 сарын 24 өдөр

№01

Баянжаргалан сум

085-1222

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17-р зүйлийн 2,6 дахь заалт, Хог хаягдлын тухай хуулийн 8.4, 9.2, 20.1, 20.2 дугаар зүйл, Сумын ИТХ-ийн 2019 оны 05 тоот тогтоолыг үндэслэлээ.

Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах түүнээс урьдчилан сэргийлэх ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, дахин боловсруулж эргүүлэн ашиглах, тээвэрлэх булах болон орчны ариун цэврийг тогтмол цэвэр байлгах, цэвэр эрүүл орчинд ажиллаж амьдрах орчныг бий болгоход оршино.

Хоёр. Гэрээ байгуулагч талууд

Нэг талаас: Дундговь, Баянжаргалан, 3-р баг, Аргатай, сумын төв хаягт байрлах **9033602** регистрийн дугаартай **Дундговь аймгийн Баянжаргалан сумын Засаг Даргын тамгын газар** /цаашид “**сумын ЗДТГ**” гэх/, түүнийг төлөөлж 2-р багийн Засаг дарга Э.Дашдамба,

Нөгөө талаас: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 1-р хороо 19-р хороолол, Чингисийн өргөн чөлөө, төв байр-44 хаягт байрлах **2095025** регистрийн дугаартай, Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа эрхэлж буй “**Монголын Алт**” (МАК) ХХК /цаашид “**Аж ахуй нэгж, байгууллага**” гэх/ түүнийг төлөөлж Хөөтийн нүүрсний уурхайн дарга В. Баттулга нар харилцан тохиролцож 2022 оны 01 сарын 01 -ний өдрөөс 2022 оны 12 сарын 31 -ийг хүртэл энэхүү гэрээг байгуулав.

Гурав. Төлбөр тооцсон байдал

Баянжаргалан сумын 2019 оны 12 дугаар сарын 19-ны ИТХ-ын 05 тогтоолд заасны дагуу:

- Сарын төлбөр **80,000** /наян мянган/ төгрөг,
- Жилийн төлбөр **960,000** /есөн зуун жаран мянган/ төгрөг байхаар тооцов.

Дөрөв. Сумын ЗДТГ эрх

1. Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын хууль, Ариун цэврийн тухай хуулийн дагуу хяналт тавьж ажиллах.
2. Иргэд аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдал гаргасны төлбөрийг төвлөрүүлэх.
3. Иргэд аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлаа зориулалтын цэгт хаяж байгаа эсэхэд хяналт тавих.
4. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх хуваарийг тээвэрлэгчтэй гэрээ байгуулж

хэрэгжилтэд хяналт тавих.

Тав. Аж ахуй нэгж, байгууллагын эрх үүрэг

1. Өөрийн байгууллагын үйл ажиллагаанаас гарсан ахуйн хуурай хог хаягдлыг стандартын шаардлага хангасан зориулалтын саванд хадгалж байх.
2. Аж ахуй нэгж, байгууллага нь хог хаягдал гарсан төлбөрөө улирал бүрийн сүүл сарын 15-ны дотор гэрээнд зааснаар Дундговь аймгийн Баянжаргалан сумын татварын байцаагчийн ирүүлсэн төлбөрийн даалгаврын дагуу цахимаар төлөх.
3. Хог хаягдлыг ангилан, ялгаж байх.
4. Ахуйн болон үйлдвэрлэлийн хогийг тогтсон хугацаанд цэвэрлэж тээвэрлэх, хог хаягдлын талаарх дүрэм журам, стандартын шаардлагыг хангаж зориулалтын цэгт хаяж байхад анхаарах.
5. Үйлдвэр үйлчилгээний явцад үүсдэг хог хаягдлын хэмжээ, бусад мэдээллийг сумын захиргаанд мэдээлж байх.
6. Хог хаягдлыг ангилан хаях талаар мэдээллийг ажилтнуудад эзэмшүүлэх, сургалт сурталчилгаа явуулах, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллах.
7. Оршин суугаа газар орчмын хог хаягдлыг цэвэрлэх, олон нийтийг хамарсан ажилд оролцох.
8. Хуульд заасан журмын дагуу олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх, хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг эрх бүхий байгууллага албан тушаалтнаас шаардах.
9. Үүссэн аюултай хог хаягдал, түүний эх үүсвэрийн талаар төрийн болон нутгийн захиргааны байгууллагад мэдээлэх.


Зургаа. Гэрээний хариуцлага

1. Аж ахуй нэгж, байгууллага нь хог хаягдал гаргасны төлбөрөө удаан хугацаагаар төлөөгүй болон ил задгай хог шатаасан, зориулалтын бус газар хог хаягдал хаясан нөхцөлд өр авлагыг барагдуулах ба учруулсан хохирлыг арилгах, шаардлагатай тохиолдолд холбогдох дээд шатны байгууллагад хандан хог хаягдлын тухай хуулийн дагуу хариуцлага тооцно.
2. Аж ахуй нэгж, байгууллага нь энэхүү гэрээнд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл Талууд тухай бүр харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

“Монголын Алт” (МАК) ХХК-г төлөөлж:

ХӨӨТИЙН НҮҮРСНИЙ УУРХАЙН
ДАРГА В.БАТТУЛГА


...../Утас:99042001/

Дундговь аймгийн Баянжаргалан сумын
ЗДТГ-ыг төлөөлж:

2-Р БАГИЙН ЗАСАГ ДАРГА
Э.ДАШДАМБА



...../Утас:94114949/

ЭРХ ЗҮГЛЭГ ГАЗАР



Нэгж талбарын дугаар: 4802000672
Улсын бүртгэлийн дугаар: Э-0805000053
Гэрчилгээний дугаар: 0000035362

ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ГАЗАР
ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ

2022 оны 3 сарын 16 өдөр

№ 04807-2020/00019

Дундговь аймаг/хот Баянжаргалан
сум/дүүрэг

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Газрын тухай хууль, Дундговь аймаг /нийслэл/-ийн Баянжаргалан дүүрэг /сум/-ын Засаг даргын 2020 оны 12 сарын 24-ны өдрийн 04807-А/96/2020 тоот шийдвэрийг үндэслэн газар эзэмшүүлэгчийг төлөөлж, Дундговь аймаг/хотын Баянжаргалан сум/дүүргийн Газрын алба, газар эзэмшигчийг төлөөлж Монголын алт МАК-ны Захирал Нямтайшир овогтой Цэлмүүннар энэхүү гэрээг байгуулав.

Хоёр. Гэрээний нөхцөл

2.1. Газар эзэмшигчид олгосон газрын нийт хэмжээ

14437779 м2

Үүнээс:

Нэгж талбарын тодорхой хэсгийг эзэмших зориулалт

Ашиглалт, олборлолт явуулж буй уурхайн талбай

Тухайн зориулалтаар эзэмших газрын хэмжээ

14437779 м2

Газар эзэмших хугацаа

15 жил

2.2. Газар эзэмших эрхийг улсын бүртгэлд бүртгэгдсэн буюу Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9.11-д заасан дундын мэдээллийн санд улсын бүртгэлийн дугаарыг оруулсан өдрөөс эхлэн хуульд заасны дагуу газрын төлбөрийг тооцож ногдуулна.

2.3. Газрын төлбөрийг нэхэмжлэхийн дагуу Татварын албанд тушаана. Газрын төлбөр төлөгч жилийн төлбөрийг тэнцүү хэмжээгээр хуваан улиралд ногдох төлбөрийг дараа сарын 20-ны өдрийн дотор төлөх бөгөөд дараа улирлуудын төлбөрийг урьдчилан төлж болно.

2.4. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр газрын суурь үнэлгээ, газрын үнэлгээний тойрог, зэрэглэл, бүс, газар эзэмших, ашиглах зориулалтын итгэлцүүр, төлбөрийн хувь, хэмжээ өөрчлөгдсөн тухай бүр уг өөрчлөлттэй холбогдуулан газрын төлбөрийг 30 хоногийн дотор шинэчлэн ногдуулна.

Гурав. Газар эзэмшигчийн эрх

3.1. Гэрээнд заасан зориулалтын дагуу уг газрыг эзэмших, ашиглах;

3.2. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг газар өмчлөгчөөс гаргуулж авах;

3.3. Газарт учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр тогтоосон журмын дагуу нөхөн төлүүлэх;

3.4. Газар эзэмшүүлэх тухай шийдвэр гаргасан этгээдийн зөвшөөрөлтэйгээр эрхийн гэрчилгээгээ бусдад шилжүүлэх, барьцаалах;

3.5. Газар эзэмшигч нь газар эзэмшүүлэх тухай шийдвэр гаргасан этгээдийн зөвшөөрөлтэйгээр тухайн газраа бүгдийг нь буюу зарим хэсгийг бусдад ашиглуулж болно.

3.6. Газрын тухай хууль тогтоомж, газар эзэмших гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлж ирсэн бол эрхийн гэрчилгээний хугацаа дуусахад уг газрыг үргэлжлүүлэн эзэмшихээр эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулах /Эрхийн гэрчилгээний хүчин төгөлдөр байх хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө эзэмшигч нь хугацаа сунгуулах тухай хүсэлтээ тухайн шатны Засаг даргад гаргах/;

3.7. Газар эзэмших эрхийн гэрчилгээ хүчингүй болсон тохиолдолд эрхийн гэрчилгээг хүчингүй болгосон Засаг даргын шийдвэрийг эрхийн гэрчилгээ эзэмшигч болон барьцаанд авсан этгээд нь

хууль бус гэж үзвэл тухайн шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй.

Дөрөв. Газар эзэмшигчийн үүрэг

- 4.1. Газар эзэмших гэрээнд заасан нөхцөл, болзлыг биелүүлэх;
- 4.2. Газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэх;
- 4.3. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг тогтоосон журмын дагуу хийлгэж байх/*5 жилд нэг удаа хийлгэнэ./*;
- 4.4. Бусдын газар эзэмшихтэй холбогдсон эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй байх;
- 4.5. Газрын төлбөрийг газрын ашигт шинж чанарыг ашигласан эсэхээс үл хамааран хуульд заасан хугацаанд нь төлөх;
- 4.6. Төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиар хэтэрсэн хоног тутамд алданги төлөх;
- 4.7. Эзэмшлийн газраа бүхэлд нь буюу зарим хэсгийг бусдад ашиглуулах бол эрх бүхий Засаг даргаас зөвшөөрөл авч, энэ тухай улсын бүртгэлд бүртгүүлэх;
